

2021 ОНЫ МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ҮЕИЙН ФЕЙСБҮҮК ДЭХ ХҮНИЙ ЭРХ, ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2021 он

2021 ОНЫ МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН
СУРТАЛЧИЛГААНЫ ҮЕИЙН ФЕЙСБҮҮК ДЭХ ХҮНИЙ ЭРХ, ХЭВЛЭЛИЙН
ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ Мониторингийн тайлан



Нээлттэй нийгэм форумын дэмжлэгээр мониторинг хийж, тайланг хэвлэв.

Хэвлэлийн хуудас: 4 х.х

Цаасны хэмжээ: А4 210х297мм

Хэвлэлийн тоо: 300 ш

© Зөвшөөрөлгүй хувилах, хэвлэхийг хориглоно.

АГУУЛГА

Мониторингийн арга зүй, аргачлал

Нэг. Сонгуулийн үеэр цахим орчинд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, хэвлэн нийтлэх эрхийн хууль зүйн баталгаа

Хоёр. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийн сурталчилгааны үеийн фейсбүүк дэх хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөний зөрчлийн мониторинг

Гурав. Сонгуулийн үеэр цахим орчинд нийтэлсэн мэдээ, мэдээллийн агуулга дахь хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн тохиолдлуудад хийсэн дүн шинжилгээ

Дөрөв. Мониторингийн дүгнэлт

Тав. Цахим орчинд хүний эрх, эрх чөлөөний зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж

Зургаа. Хавсралтууд



МОНИТОРИНГИЙН АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО:

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны үед нийгмийн хэвлэл мэдээлэл (фейсбүүк)-д үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөний хэрэгжилт хэр түвшинд байгаа, мөн хүний эрхийн ноцтой зөрчил бүхий кейсүүдэд эрх зүйн шинжилгээ хийж, зөвлөмж боловсруулахад чиглэнэ.

Уг зорилгыг хангахын тулд дараах хоёр төрлийн судалгааны ажлыг зохион байгууллаа.

Үүнд:

1. Фейсбүүк дэх хүний эрхийн зөрчилтэй, үзэн ядалтын үг хэллэг ашигласан, гутаан доромжилсон, үймээн самуунд уриалсан пост болон сэтгэгдлийг тодорхой түлхүүр үгс ашиглан Кудос (Kudos) программын

тусламжтайгаар хайлт хийж түүвэрлэн авав. Түүвэрлэсэн мэдээлэлд тоон болон чанарын шинжилгээ хийж тайлангийн 2 дахь бүлэгт оруулав.

2. Мониторингийн явцад анхаарал татсан хүний эрхийн болон хэвлэлийн эрх чөлөөний зөрчил бүхий хэд хэдэн жишээг түүвэрлэн авч хуульч судлаачаар хууль, эрх зүйн талаас тайлбар дүн шинжилгээ хийлгэлээ. Мөн цахим орчин дахь эрх зүйн зохицуулалт, хязгаарлалтууд, тулгарч буй бэрхшээл сорилын талаарх тайлбарыг тайлангийн 1-р бүлэгт, мониторингийн явцад илрүүлсэн хүний эрхийн ноцтой зөрчил бүхий жишээнүүдэд хийсэн дүн шинжилгээг тайлангийн 3 дахь бүлэгт орууллаа.

МОНИТОРИНГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ:

Монгол улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль 2021 оны зургаадугаар сарын 9-нд товлогдож, сурталчилгаа нь 15 хоног үргэлжлэв. "Монгол Улсын Ерөнхийлөгчийн Сонгуулийн Тухай Хууль"-ийн 42 дугаар зүйлд сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах асуудлыг зохицуулсан.

Нийгмийн хэвлэл мэдээллийн фейсбүүк талбар дахь хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөний хэрэгжилтийг тандах зорилгоор Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид, нэр дэвшүүлсэн намын албан ёсны сошиал хуудаснуудаас гадна олон хэрэглэгчтэй хэвлэл мэдээллийн байгууллага, нийтийн групп, пэйжүүдийг хамруулан цахим орчинд мэдээлэл хайлтын Кудос-Медиа мониторинг системийн дэмжлэгтэйгээр мониторинг хийлээ.

Мониторингийн анхдагч мэдээллийг цуглуулахдаа Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны 15 өдрийг хамруулан урьдчилан боловсруулсан тодорхой түлхүүр үгсээр фейсбүүк талбарт хайлт хийн мэдээллийн дата санг бүрдүүлэв. Улмаар бүрдүүлсэн мэдээлэл/постуудын сэтгэгдэл хэсгийг мониторингийн багийнхан нэг бүрчлэн, тэр тусмаа хүний эрхийн зөрчил агуулсан сэтгэгдлүүдийн хамт бүртгэж авлаа.

Хүний эрхийн зөрчил агуулсан пост болон сэтгэгдэлд хүний эрхийн чиглэлээр мэргэшсэн хуульч судлаачаар дүн шинжилгээ хийлгэж эрх зүйн тайлбар дүгнэлт, зөвлөмжийг гаргууллаа. Ингэснээр тус мониторингийн онцлог, шинэлэг байдал хангав.



МОНИТОРИНГИЙН ХҮРЭЭНД ДАРААХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЛЭЭ. ҮҮНД:

- 1) Сонгуулийн үеэр цахим орчинд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, хэвлэн нийтлэх эрхийн хууль зүйн баталгааны талаар тойм бэлтгэв.
- 2) Ерөнхийлөгчийн ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн цахим орчин дахь хүний эрхийн хамгаалалт, хувийн нууцад хүндэтгэлтэй хандах, ялгаварлан гадуурхалт, доромжлол, үзэн ядалтын бай болгож буй эсэхэд мониторинг хийж, зөрчлүүдийг бүртгэв. Зөрчлийг бүртгэхдээ мониторингийн зорилгыг хангах шалгуур үзүүлэлтүүдийг тогтоож, түлхүүр үгсийг бэлтгэн, тусгайлсан программ хангамжийг сонгож ашиглалаа.
- 3) Нийгмийн хэвлэл мэдээллийн мониторингийг фейсбүүк талбарт төвлөрөн хийсэн бөгөөд сурталчилгааны өмнөх гурав хоногт туршилтын судалгаа хийсэн. Энэхүү судалгаа амжилттай болсон нь сурталчилгааны үеийн 15 хоногт иж бүрэн мониторинг гүйцэтгэх суурь болсон юм.
- 4) Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны үеийн нийгмийн хэвлэл мэдээлэл (фейсбүүк)-д нэр дэвшигчдийн талаарх хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотой мэдээлэлд ажиглалт хийсний үндсэн дээр хуульч судлаач тодорхой тохиолдол, жишээнүүдэд гүнзгийрүүлсэн дүн шинжилгээ хийв.
- 5) Хүний эрхийн зөрчил бүхий пост/мэдээллийн сэтгэгдэл хэсэгт нарийвчилсан ажиглалт хийж, хамгийн түгээмэл ашигласан үг хэллэг, троллинг урсгалыг илрүүлэхийг зорив.
- 6) Сонгуулийн үед иргэд үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө цахим талбарт хэрхэн хэрэгжүүлж буйд дүгнэлт, зөвлөмж гаргалаа.

Фейсбүүкт хүний эрхийн зөрчлийн мониторинг хийх аргачлал:

Зайлшгүй түлхүүр үгс: 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч

- У.Хүрэлсүх /Монгол Ардын Нам/
- С.Эрдэнэ /Ардчилсан Нам/
- Д.Энхбат /Зөв хүн электорат эвсэл/

Зайлшгүй бус түлхүүр үгс:

Хүний эрхийн зөрчилтэй үзэн ядсан, ялгаварлан гадуурхсан, хэвшмэл хандлага бүхий доромж үгс

Нийт 78 түлхүүр үгс /Хүснэгт 1-ээс харна уу/

Хайлтын талбар: Фейсбүүк пэйж, аккаунт, групп

Мэдээлэл боловсруулах үе шат:

Кудос-Медиа мониторинг системийн тусламжтайгаар тодорхой түлхүүр үгсээр фейсбүүкийн постод хайлт хийх зарчмаар илэрсэн бүх мэдээллийг бүртгэж тоон мэдээллийг боловсрууллаа. Сэтгэгдэл хэсэгт түлхүүр үгээр хайлт хийхэд хайлтын систем ажиллахгүй

болохыг сануулж байсан. Өөрөөр хэлбэл, хайлтын хугацааг нэг сараар тохируулан сэтгэгдэл хэсгээс түлхүүр үгээр хайлт хийсэн. Гэтэл өдрийн сонголтод илэрц байгаагүй тул сэтгэгдэл хэсэгт агуулгын шинжилгээг нэмж хийсэн болно.

Мониторингийн хязгаарлагдмал тал:

Энэ удаагийн мониторингт бид цахим хайлтын Кудос-Медиа мониторинг системийг ашигласан тухай өмнө дурдсан. Технологийн хязгаарлагдмал нөөц боломжоос шалтгаалан зөвхөн public тохиргоотой постуудаас түлхүүр үгээр хайлт хийсэн. Дараа нь илэрцүүдийг түүвэрлэн авч тоон үр дүнг боловсрууллаа. Ингэснээр фейсбүүк дэх хүний эрхийн зөрчил агуулсан бүхий л мэдээлэлд бус харин тодорхой хязгаарлагдмал хүрээнд ажилласан болохыг үгүйсгэхгүй.

Гэвч фейсбүүк дэх хүний эрхийн зөрчилтэй, үзэн ядах үг хэллэгтэй мэдээлүүдийг илрүүлэх, судалгаанд суурилсан дүгнэлт, зөвлөмж гаргахад уг программ хангамж ихээхэн дэмжлэг болсныг судалгааны

багийнхан онцлон тэмдэглэв.

Мониторингийн анхдагч мэдээлэлд судлаачдын субъектив нөлөөлөл оруулахаас урьдчилан сэргийлж, хүний эрхийн суурь мэдлэг олгох, хайлт хийх түлхүүр үгсийг сонгох, хайлтын программ хангамжийг үр дүнтэй ашиглах чиглэлээр сургалт зохион байгуулж, туршилтын судалгаа хийсэн болно.

Кудос-Медиа мониторинг системийг үндэсний Болорсофт ХХК хөгжүүлсэн бөгөөд дата олборлолт, медиа мониторинг, тайлан дүн шинжилгээ хийхэд зориулагдсан. Нийгмийн хэвлэл мэдээлэл, цахим мэдээний сайтууд, тэдгээрийн сэтгэгдэл хэсэгт түлхүүр үгээр хайлт хийж хүссэн мэдээлээ богино хугацаанд илрүүлэх боломжтой аж.



Хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөний зөрчилд дүн шинжилгээ хийх шалгуур үзүүлэлтүүд:

Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааг хууль эрх зүйн орчинд хэрхэн зохицуулсан, ямар сорил бэрхшээл, боломжууд байгаа тухай тоймлон бэлтгэв. Улмаар цахим орчин тэр дундаа фейсбүүк дэх хүний эрхийн зөрчилд дүн шинжилгээ хийхдээ:

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
- Монгол улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж, журмуудыг шалгуур үзүүлэлт болгон баримтална.

Мониторингоор илрүүлсэн хүний эрхийн ноцтой зөрчил бүхий жишээнүүдэд эрх зүйн дүн шинжилгээ хийхдээ:

- Хүнлэг энэрэнгүй байх;
- Шударга, алагчлалгүй байх;
- Хүний жам ёсны эрхэд хүндэтгэлтэй хандах;
- Жендерийн эрх тэгш байдал;

- Ялгаварлалгүй хандах гэх мэт шалгуур үзүүлэлтүүдийг харгалзсан болно.

Сонгуулийн сурталчилгааны хугацаанд фейсбүүкээр олон нийтэд хүрсэн хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөний зөрчилтэй 10 хүртэлх кэйс /постын агуулга, олон нийтийн сэтгэгдэлд/ дүн шинжилгээ хийв.

Ингэхдээ тухайн зураг, дүрс, текст бүхий пост болон олон нийтийн сэтгэгдэл нь бусдыг үндэс угсаа, хүйс, шашин шүтлэг, нийгмийн гарлаар нь ялгаварлан гадуурхсан эсэх, хувийн орон зай болох гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн халдан оролцож байгаа эсэхийг хууль зүйн үүднээс тайлбарлалаа.

Мөн тухайн пост, сэтгэгдэл нь бусдын үзэл бодол, итгэл үнэмшилд нь нөлөөлж нийгмийн аюулгүй байдал, дэг журам алдагдахад өдөөн турхирах хандлага гаргасан уу, үгүй юу гэдгийг ч ажиглаж тэмдэглэсэн юм.

НЭГ. СОНГУУЛИЙН ҮЕЭР ЦАХИМ ОРЧИНД ҮЗЭЛ БОДЛОО ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ, ХЭВЛЭН НИЙТЛЭХ ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН БАТАЛГАА

Монгол Улсын Их Хурлын 2021 оны нэгдүгээр сарын 20-ний өдрийн “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 07 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг 2021 оны нэгдүгээр дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэхээр товлон зарлаж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийн санал авах өдрийг 2021 оны зургаадугаар сарын есний өдөр байхаар тогтоосон.

Сонгуулийн Ерөнхий Хорооны 2021 оны хоёрдугаар сарын тавны өдрийн 06 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021

оны ээлжит сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах цаг хугацааны хуваарь”-ийг баталсан. Тус хуваарийн 35-д зааснаар сонгуулийн сурталчилгааг 2021 оны тавдугаар сарын 24-ний өдрөөс эхлүүлж, мөн оны зургаадугаар сарын долооны өдрийг дуустал үргэлжлүүлнэ.

Үүнтэй холбоотойгоор сонгуулийн үеэр цахим орчинд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, хэвлэн нийтлэх эрхийн хууль зүйн баталгааны эрх зүйн орчны зохицуулалтыг дараах дэд сэдвийн хүрээнд тоймлон бэлтгэлээ.

1.1 Сонгуулийн хууль тогтоомж болон бусад эрх зүйн акт дахь цахим орчны зохицуулалт

1.1.1 Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаа

“Монгол Улсын Ерөнхийлөгчийн Сонгуулийн Тухай Хууль”-ийн 42 дугаар зүйлд сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах асуудлыг зохицуулсан. Энэхүү зохицуулалтын дагуу:

- Нэр дэвшигч нь нэр дэвшигчийн болон нам, эвслийн өөрийн тус бүр нэг цахим хуудас; цахим орчин дахь олон нийтийн сүлжээний нэг цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах тохиолдолд цахим хуудсыг нэр

дэвшигчийн үнэмлэх авсан өдрөөс хойш гурав хоногийн дотор Харилцаа Холбооны Зохицуулах Хороонд бүртгүүлнэ.

- Нэр дэвшигчийн болон нам, эвслийн өөрийн тус бүр нэг цахим хуудас, бусад цахим хуудас ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахдаа сэтгэгдэл бичигдэхгүй тохиргоотойгоор нийтэлнэ.
- Харилцаа Холбооны Зохицуулах Хороонд



бүртгүүлээгүй цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах, бусдын нэр болон хуурамч хаяг ашиглахыг тус тус хориглоно.

Дээрх зохицуулалтын дагуу Сонгуулийн Ерөнхий Хорооны 2020 оны дөрөвдүгээр сарын 14-ний өдрийн 21 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам”-ын 3.7-д заасан хугацаанд буюу 2021 оны тавдугаар сарын 21-ний дотор нийт 574 цахим үйлчилгээ эрхлэгч Харилцаа Холбооны Зохицуулах Хороонд бүртгүүлсэн байна. Үүнээс Фейсбүүк хуудас 254, цахим хуудас 202, Твиттер хаяг 58, Ютүб суваг 36, Инстаграм хаяг 14, бусад төрлийн 10 аппликейшн цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулахаар бүртгүүлжээ.¹

Энэхүү зохицуулалтын дагуу нэр дэвшигчийн болон нам, эвслийн өөрийн болон бусад цахим хуудас ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахдаа сэтгэгдэл бичигдэхгүй тохиргоотой байх нь тухайн сурталчилгаанд дурдсан агуулгатай холбоотой сэтгэгдэл бичих хэлбэрээр сонгогчид үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг хязгаарласан нь зохисгүй байна.

Түүнчлэн Харилцаа Холбооны Зохицуулах Хороонд бүртгүүлээгүй цахим хуудас дахь мэдээллийг дамжуулах асуудлыг зохицуулаагүй орхисноороо нэр дэвшигчид тэнцвэргүй, хууль тогтоомжид нийцээгүй мэдээллийг сонгогчдод хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Тухайлбал, Монгол Ардын Намын <https://www.facebook.com/Ardiinnam/> хуудсыг Харилцаа Холбооны Зохицуулах Хороонд бүртгүүлсэн байх бөгөөд энэхүү бүртгэлтэй фэйсбүүкийн хуудсаар 2021.05.24, 2021.05.25, 2021.05.28 болон 2021.06.01-ний өдөр дамжуулсан “eNAM” апп болон “NextGen” подкастын хувьд бүртгэлгүй байгаа юм.

Энэ тохиолдолд Сонгуулийн Ерөнхий Хорооны 2020 оны дөрөвдүгээр сарын 14-ний өдрийн 21 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах,

түүнд хяналт тавих журам”-ын 4-т зааснаар дараах арга хэмжээ авах боломжтой байна:

- Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаатай холбоотой өргөдөл, гомдлыг цагдаагийн байгууллага, тагнуулын байгууллага, шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.
- Эдгээр байгууллага нь цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаатай холбоотой өргөдөл, гомдлыг хүлээн авч холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан үзээд эрх бүхий албан тушаалтны шийдвэр бүхий албан бичиг, дүгнэлтийг Харилцаа Холбооны Зохицуулах Хороонд хүргүүлнэ.
- Тус албан бичиг, дүгнэлтэд тухайн мэдээ, мэдээллийн цахим хаяг, цахим холбоос, хэвлэмэл баримт зэрэг шаардлагатай баримтыг хавсаргана.
- Харилцаа Холбооны Зохицуулах Хороо нь тус албан бичиг, дүгнэлтийн дагуу дараах мэдэгдлийг цахим үйлчилгээ эрхлэгчдэд нэн даруй хүргүүлнэ.
 - Мэдэгдэлд дурдсан мэдээ, мэдээллийг устгах эсвэл хандалтыг хаах, эсхүл түр хязгаарлах;
 - Мэдэгдэлд дурдсан цахим хаяг, цахим хуудсыг сонгуулийн сурталчилгааны хугацаа дуустал хандалтыг хаах, эсхүл түр хязгаарлах.

Мөн Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйл / Сонгуулийн хуулийг зөрчих/-ийн 13-т “Сонгуулийн сурталчилгаанд хуульд заасны дагуу бүртгүүлээгүй цахим хуудас ашигласан, эсхүл бусдын нэр болон хуурамч цахим хаяг ашигласан бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасны дагуу дээрх асуудалд хариуцлага хүлээлгэх зохицуулалт байна.

¹ - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1, 42.1.2-д заасны дагуу сонгуулийн сурталчилгаа явуулахаар бүртгүүлсэн цахим хуудаснуудын жагсаалт. 2021.05.27 <https://crc.gov.mn/k/38N>

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3, 42.5-д заасны дагуу сонгуулийн сурталчилгаа явуулахаар Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлсэн бусад цахим хуудаснуудын жагсаалт. 2021.05.28 <https://crc.gov.mn/w/38H>



1.1.2. Цахим орчинд сонгуультай холбоотойгоор үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө

Зөрчлийн тухай хуульд “Улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг зөрчил” гэх 17 дугаар бүлгийг 2019 оны 12-р сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн. Үүний дагуу “Зөрчлийн тухай хууль”-ийн 17.1 дүгээр зүйл / Сонгуулийн хуулийг зөрчих/-ийн 7-д нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд тараасан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол” хүнийг 5 сая төгрөгөөр, хуулийн этгээдийг 50 сая төгрөгөөр торгоно гэж заасан.

Мөн Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйл /Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах/-ийн 1-т “Сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан бол” 450,000 төгрөгөөс 5,400,000 төгрөгөөр торгох, 240 зуун дөчин цагаас 720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ, 2-т “Энэ гэмт хэргийг төрийн албан хаагч, сонгуулийн хорооны албан тушаалтан, ажилтан үйлдсэн бол” нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар нийтийн албанд томилогдох эрх хасаж 1,350,000 төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж заасан.

Эндээс харахад, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулиар нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг хамгаалсан байх бөгөөд нэр дэвшигчийн талаарх худал болон илт худал мэдээллийг тараасан үйлдэлд хариуцлага хүлээлгэхээр байна. Эдгээр зохицуулалтад “худал мэдээлэл” ба “илт худал мэдээлэл” гэдгийг тодорхойлоогүй, түүнчлэн нэр дэвшигч холбогдох бодит, зөв мэдээлээ урьдчилж нийтэд мэдээлснээс хойш худал мэдээлэл тараасан эсэхийг харгалзах

талаар орхигдуулсан байна. Тодруулбал, сонгогчийн тараасан мэдээлэл нь нэр дэвшигчийн холбогдох мэдээлэл ил болоогүй буюу хуучирсантай холбоотой эсэх, эсхүл тийнхүү бодит, зөв мэдээлэл ил болсон байхад зориуд худал мэдээлэл тараасан эсэхийг харгалзахгүйгээр шийтгэл оноогоор зохицуулсан нь өрөөсгөл байна. Энэ нь цахим орчинд сонгуультай холбоотойгоор үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зохисгүйгээр хязгаарласан шинжтэй байна.

Харин Эрүүгийн хэргийн шүүх Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулахаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан тул нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээлэл эсэхийг цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч бус шүүгч тодорхойлох бөгөөд дээрх зохицуулалтыг зохисгүйгээр буюу буруу хэрэглэх эрсдэлийг бууруулж байна.

Мөн нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон “худал мэдээлэл” тараасан бол Зөрчлийн тухай хуулиар 5 сая төгрөгөөр, “илт худал мэдээлэл” тараасан бол Эрүүгийн хуулиар 450,000 төгрөгөөр торгохоор байгаа нь зөрчил, гэмт хэргийн ялгааг харгалзаагүй, зөрчлийн шинж байдал ба шийтгэлийн төрөл, хэмжээг огт уялдуулаагүй байх бөгөөд зөрчлийн шинжтэй үйлдлийг шууд эрүүгийн хэргийн журмаар шалгаж шийдэх үр дагаврыг бий болгож байна. Эрүүгийн хуульд зааснаас хүнд шийтгэлийг Зөрчлийн тухай хуульд заасныг сонгуультай холбоотойгоор үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зориуд хязгаарласан гэж үзэхэд хүргэж байна.

1.2 Нийгмийн хэвлэл мэдээллийн талаарх зохицуулалт: Монгол Улсын болон бусад улс орны сайн туршлагаас

Харилцаа Холбооны Зохицуулах Хороо /ХХЗХ/ “Фейсбүүк” компанитай албан ёсоор харилцах “Ногоон суваг” (Government-Case-Work-Channel)-ыг 2019 оны 10 дугаар сараас албан ёсоор нэвтрүүлсэн. Энэ хүрээнд УИХ-ын 2020 оны сонгуулийн хугацаанд ХХЗХ-нд эрх бүхий байгууллага /ЦЕГ, ШӨХТГ, ТЕГ, МХЕГ/-аас 322 санал, дүгнэлт ирүүлсэн. Эдгээр хүсэлтийг ХХЗХ-ноос “Фейсбүүк” компанид хүргүүлж, эдгээр 322 хүсэлтийн 284-ийг Фейсбүүк компаниас

шалгаж холбогдох хариуг ирүүлсэн байна. УИХ-ын сонгуулийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн нийт хаяг, хууль бус контентын 63 хувийг нь шийдвэрлэсэн байна. Харин үлдсэн 38 санал, дүгнэлтэд нь Фейсбүүк компанийн зүгээс ямар нэгэн хариу ирээгүй байна.²

“Ногоон суваг”-ын хамтын ажиллагааг сайжруулах, хууль бус контентын талаарх гомдол, хүсэлтийг шуурхай шийдвэрлэх зорилгоор 2021 оны

² -Т.Батболд: Сонгуулийн хугацаанд “Фейсбүүк” компанитай хамтран хууль зөрчсөн 403 контентыг хязгаарласан. 2020.08.04 <https://crc.gov.mn/k/33X>



дөрөвдүгээр сараас “Content Reporting System”-ийг нэвтрүүлэн Фейсбүүк компанитай хамтран ажиллахаар болжээ. Тус системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд 2021 оны гуравдугаар сарын 24-ны өдөр Харилцаа Холбооны Зохицуулах Хороо Фейсбүүк компанитай цахим уулзалт зохион байгуулж, Content Reporting System-ыг хэрхэн нэвтрүүлэх, мөн 2021 оны зургаадугаар сард зохион байгуулагдах Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хугацаанд хэрхэн хамтран ажиллах талаар хэлэлцсэн байна.³

Нийгмийн хэвлэл мэдээллийн нөлөө бүхий компани болох Фейсбүүкийн үзэж буйгаар, Засгийн газар, зохицуулах байгууллагууд илүү идэвхтэй үүрэгтэй байх шаардлагатай бөгөөд интернэтийг хортой агуулга, сонгуулийн хараат бус байдал, хувийн нууц – халдашгүй байдал, өгөгдлийн шилжилт хөдөлгөөн гэсэн дөрвөн чиглэлээр шинэ зохицуулалт хэрэгтэй байна. Энэ нь цаашид цахим орчинд төрийн үүрэг, оролцоо нэмэгдэх хандлагатай байгааг харуулж байна. Иймд Монгол улсад цахим орчныг зохицуулахдаа цахим орчин дахь хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байхад онцгой анхаарч, дараах шалгуураар хууль тогтоомжийг боловсруулах, хэрэгжүүлэх нь зүйтэй байна.⁴ Үүнд:

- Цахим орчинд аюулгүй байдлаа хэрхэн хангах талаар хэрэглэгчдэд зориулсан мэдлэг олгох, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг цахим орчныг зохицуулах хууль тогтоомжийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болгох;
- Цахим орчинд эрх нь зөрчигдсөн буюу тийнхүү зөрчигдөх бодит эрсдэлтэй хэрэглэгчийн гомдлыг хүлээн авч, шалган шийдвэрлэх үр дүнтэй механизм бий болгох;
- Цахим орчин дахь илт хууль бус агуулгыг хэт өргөн хүрээнд бус, тодорхой, хоёрдмол утгагүйгээр, нэг мөр ойлгож хэрэглэх боломжтой байдлаар тусгайлан тодорхойлох;
- Цахим орчин дахь илт хууль бус агуулгыг арилгах, тийм агуулгаас сэргийлэх үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг зөрчих нөхцөл болох ёсгүйг онцгойлон анхаарч зохицуулах.
- “Терроризмтой тэмцэх”, “үндэсний аюулгүй байдлыг хангах” хүрээнд хууль бус болон зохих үндэслэлгүйгээр хэвлэлийн эрх чөлөөг цагдан хянах, иргэдийн захидал харилцааг хэт мөрдөн тагнахгүй байх, мэдээллийг шифрлэх технологийг ямар нэг байдлаар хязгаарлахгүй байх нөхцөлийг заавал тусгах.

1.3 Цахим орчин дахь троллуудтай тэмцэх буюу үзэн ядалтын үг хэллэгээс үүдсэн гэмт хэргээс сэргийлэх зохицуулалт

Тролинг буюу интернэт тролл нь цахим сүлжээний харилцааны соёлын хэм хэмжээг зөрчиж бусдын харилцаа, танин мэдэхүй, мэдлэгийн солилцоо, иргэдийн амар тайван байдлыг алдагдуулах, ярианы сэдвээс хазайж уншигчдын сэтгэл хөдлөлийг ашиглан талцуулж, маргаан үүсгэж буй үйлдлийг хэлнэ. Тролинг бүр өөрийн онцлог шинж чанартай, үйлдэх зорилго, шалтгаан нь ялгаатай байдаг бөгөөд хувь хүн, олон нийт, хэсэг бүлэг хүмүүс рүү чиглэдгээрээ онцлогтой. Тролингийг дурын хэн нэгэн ихэвчлэн “youtube”, блог, форум, и-мэйл, фейсбүүк, твиттер, мэдээний сайт зэрэг олон нийтийн сүлжээгээр comment бичих хэлбэрээр хийдэг байна. Сүүлийн үед троллингийг улс төрийн хүрээнд ихээр хэрэглэж байгаа. Интернэт орчинд нийтлэл, хэлэлцүүлэгтэй холбоогүй зүйлийг бичих, санаатайгаар хэн нэгнийг

өдөөн хатгах зэргээр улс төрийн үйл ажиллагаанд ашиглах болжээ. Түүнчлэн улс орнуудын засгийн газар, бүлэглэл болон байгууллагууд өөрийн ашиг сонирхлын хүрээнд олон нийтийн санааг эргүүлэх, мэтгэлцүүлэх зорилгоор ашиглаж эхэлсэн байна.⁵

“Цахим цэрэг”-ээр дамжуулан цахим орчинд буюу фейсбүүк, твиттер, “WhatsApp”, “YouTube”, “Instagram” хэрэглэгчдийн тархи угаах үйл ажиллагаа явуулж буй улсын тоо нэмэгдэх боллоо. Эдгээр улсад ийнхүү цахим орчинд тархи угаахдаа хүний үндсэн эрхийг зөрчих, улс төрийн өрсөлдөгчийг гутаан доромжлох, эсрэг буюу ялгаатай үзэл бодлыг хаах байдлаар нийгэм дэх мэдээллийг хянаж байна.⁶ Энд дурдсан 70 улсын тоонд интернэтийн эрх чөлөөтэй гэгдэх орон ч багтаж байна. Энэ нь цахим орчин дахь хүний эрх, эрх чөлөөг зөрчигдөхөөс сэргийлэх буюу

³ ХХЗХ, Фейсбүүк компани “Ногоон суваг”-ын хүрээнд CRS системээр хамтран ажиллана. 2021.03.26 <https://crc.gov.mn/k/37y>

⁴ Глоб Интернэшнл төв. Нийгмийн хэвлэл мэдээллийн зохицуулалт /Судалгаа/. 2019 https://www.gic.mn/public/docs/publications/survey_result_social_media_regulation_191024.pdf

⁵ Тагнуулын ерөнхий газар. Тролинг буюу интернэт тролл гэж юу вэ?. 2018.04.28 <https://gia.gov.mn/12/item/369>

⁶ Samantha Bradshaw, Philip N. Howard. The Global Disinformation Order: 2019 Global Inventory of Organised Social Media Manipulation. 2019 <https://comprop.oii.ox.ac.uk/wpcontent/uploads/sites/93/2019/09/CyberTroop-Report19.pdf>



хууль хэрэгжүүлэгчдийн үйл ажиллагаанд иргэний нийгмийн зүгээс тогтмол хяналт тавьж байх нь чухал болохыг харуулж байна.

Иргэдийг зохион байгуулалтад оруулж, нэг дор төвлөрүүлэн ажилладаг, хүмүүсийн хэлж заншсанаар “хөлсний бичээч” хийдэг, улмаар үзэн ядалтын үг хэллэгийг тараадаг үйлдлийг ХХЗХ хянах эрх, үүрэг байхгүй. Үүнийг ЦЕГ, ТЕГ зэрэг холбогдох байгууллага хариуцан ажиллаж байна. Тодруулбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-т зааснаар Эрүүгийн хуулийн 19.9 дүгээр зүйл /Үндэсний эв нэгдлийг бусниулах/-ийн 1-т “Хүмүүсийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашны номлол, үзэл бодлоор дайсагнуулах, эвдрэлцүүлэх, салан тусгаарлахыг ухуулсан, уриалсан, ялгаварлан гадуурхсан, хүчирхийлсэн, эрхийг нь хязгаарласан, давуу байдал тогтоосон үйлдлийг зохион байгуулсан...”, 20.1 дүгээр зүйл /Террорист үйлдлийн талаар зориуд худал мэдээлэх/-ийн 1-т “... нийгэмд аюултай өөр хор уршиг учруулахад бэлтгэж байгаа талаар зориуд худал мэдээлсэн ...”, 20.2 дугаар зүйл /Террорист үйл ажиллагаанд уриалах, түүнийг нийтийн өмнө зөвтгөх, хатгах/-ийн 1-т “Терроризмын суртал ухуулга явуулсан, эсхүл түүнийг дэлгэрүүлсэн,

эсхүл террорист үйл ажиллагаа явуулахыг уриалсан, эсхүл олон нийтийн өмнө зөвтгөсөн, эсхүл бусад этгээдийг хатгасан ...” гэж тус тус заасан гэмт хэрэгт Тагнуулын байгууллага хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна. Эрүүгийн хуулийн 14.1 дүгээр зүйл /Ялгаварлан гадуурхах/-ийн 1-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан...” гэж заасан гэмт хэрэгт цагдаагийн байгууллага хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна.

Цахим орчин дахь тархи угаалтаас сэргийлэхийн тулд цахим сүлжээнд өөрт нь байдаг тархи угаалгах, худал мэдээ хүлээн авахаас сэргийлсэн зохицуулалтыг мэддэг байх хэрэгтэй. Учир нь фейсбүүк, твиттер, YouTube-н технологийн зохицуулалт буюу боломжийг бүрэн мэддэггүйтэй холбоотойгоор цахим орчин дахь худал мэдээллийн нөлөөнд автах нь бий. Цахим сүлжээнд тархи угаалгах, худал мэдээ хүлээн авахаас сэргийлэх зохицуулалтыг Фейсбүүкийн жишээн дээр авч үзье.

Зохицуулалт	Фейсбүүк (Facebook)
Ажлын арга барил	- Машин болон хүн аль аль нь ажилладаг - 20 мянган хүнтэй баг контентод дүгнэлт хийдэг.
Агуулга, сурталчилгааг шүүх, устгах	- Шүүх, устгах үйлдэл хийдэг - Биед хохирол учруулах агуулгыг устгадаг /терроризм, үзэн ядах, амиа хорлох/
Агуулга, сурталчилгааг хаах	- Агуулгад соёл/үндэсний хязгаарлалт бий.. - Хэрэглэгчид хуудас, хүмүүсийг нуух, 30 хоног мартах боломжтой.
Агуулга, зар сурталчилгааг эрэмбэлэх	Олон нийт, бүлгийн зүгээс найдвартай гэж үзсэн эх сурвалжийн агуулгыг дээгүүр эрэмбэлнэ. Товшуур нь тухайн гарчиг, агуулгыг багтаасан мэдээллийн ач холбогдлыг бууруулах замаар эрэмбэлдэг. Фейсбүүк нь худал мэдээллийн дор баримтыг нягтлан шалгасан нийтлэлийг байрлуулдаг. Хэрэглэгчид өөрсдөө ямар хуудас, хүнийг эхэнд үзэхээ тохируулж болдог. Улс төрийн зар сурталчилгаа, хуудсын эх үүсвэрийг шошгожуулдаг
Бүртгэл, хаягийг идэвхгүй болгох, түр зогсоох	- Анхааруулга өгдөг, боломжийг хязгаарладаг, бүртгэлийг түдгэлзүүлдэг. Таны тавьсан зар сурталчилгааны ангиллыг үзэх, өөрчлөх боломжтой.



ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2021 ОНЫ СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ҮЕИЙН ФЕЙСБҮҮК ДЭХ ХҮНИЙ ЭРХ, ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЗӨРЧЛИЙН МОНИТОРИНГ

Нийгмийн хэвлэл мэдээллийн (фейсбүүк) мониторингийг сонгуулийн сурталчилгааны буюу 2021 оны тавдугаар сарын 24-нөөс зургаадугаар сарын долоон хүртэл нийт 15 хоногийн хугацаанд зохион байгууллаа.

Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн албан ёсны фейсбүүк хаяг болон улс төрийн намуудын фейсбүүк пэйж, монголын хамгийн олон хэрэглэгчтэй пэйж/групп, зарим хэвлэл мэдээллийн байгууллагын фейсбүүк пэйжэд байршуулсан мэдээ, мэдээлэлд хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөний хэрэгжилтэд хараат бусаар ажиглалт хийсэн юм.

Фейсбүүк дэх хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөний зөрчлийн мониторингийг хийхдээ Кудос-Медиа мониторинг системийн тусламжтайгаар тодорхой түлхүүр үгсээр хайлт хийж хүний эрхийн зөрчилтэй, үзэн ядалтын үг хэллэг ашигласан, гутаан доромжилсон, үймээн самуунд уриалсан бүхий л мэдээллийг бүртгэж тоон мэдээллийг нэгтгэн боловсрууллаа.

Ингэхэд, сонгуулийн сурталчилгааны үеэр хамгийн идэвхтэй ажилласан фейсбүүк хуудаснуудаас гол мэдээллүүдийг бүрдүүлэв. (Хавсралт 1-ээс харна уу)

Хүснэгт 1. Мониторингийн хүрээнд хайлт хийхдээ ашигласан түлхүүр үгсийн жагсаалт

Түлхүүр үгс			
№	У.Хүрэлсүх	С.Эрдэнэ	Д.Энхбат
1	Манан	Алуурчин	Дангаасүрэнгийн энхбат
2	Manan	Гэмт хэрэгтэн	Dangaasuren Enkhat
3	Khurelsuh	Шорон зан	ХҮН
4	Khurelsukh	Дарангуйлагч	Элитист
5	Ухнаагийн хүрэлсүх	ковидизм	Элит
6	nohook	Ардчилсан монгол	Сэхээтэн
7	nohuuk	Дарангуйлалгүй монгол	Боловсролтой
8	коммунист	Содномзундуйн Эрдэнэ	Инженер
9	соц	erdene	Эрлийз
10	Хужаа	эрлийз	Хужаа
11	адүүчин	АН-ын дарга	Хятад
12	Эрлийз	АН	оюунлаг
13	Хужаа	Намчирхах	элитист үзэлтэй
14	хятад	хужаа	элитист үзэлтэн
15	МАН	нийгмийн даатгал	зөв хүн
16	хүүк	Баянголын эрдэнэ	ЭЛЕКТОРАТ эвсэл
17	гарын булчин	#voteErdene	Монгол чадна
18	хурандаа хүрэлсүх	салсан	#МонголЧадна
19	оффшорчин	хятад	Монгол ХҮН
20	оффшордож	оффшорчин	Сорос
21	хүчээ нэгтгэе	оффшордож	тархины булчин
22	ардын хүү	МАНАН	дата ком
23	эх оронч хүү	MANAN	ХҮРЭЛ ЗЭВСЭГИЙН ҮЕ
24	еөк		МАНАН
25	MAN		MANAN



26	нэг намын дарангуйлал		
27	ЖДҮ		
28	Боловсролгүй		
29	ХҮРЭЛ ЗЭВСЭГИЙН ҮЕ		
30	hurelsuh		

Фейсбүүк дэх хүний эрхийн байдал мониторингийн тоон үр дүн

Сонгуулийн сурталчилгааны 15 хоногт фейсбүүк талбараас хүний эрхийн болон хэвлэлийн эрх чөлөөний зөрчлийг агуулсан байж болзошгүй хэмээн үзсэн нийт 579 мэдээлэл/постыг Кудос-медиа мониторинг системийн тусламжтайгаар бүртгэж дүн шинжилгээ хийлээ. Уг систем нь цахим талбараас тодорхой түлхүүр үгсийн тусламжтайгаар мэдээллийг түүвэрлэн илрүүлдэг бөгөөд эдгээр илэрцэд нэр дэвшигчидтэй холбоотой эерэг, сөрөг, төвийг сахисан

төрөл бүрийн мэдээлэл багтаж байв. Тухайлбал, хүүк гэсэн түлхүүр үгийн илэрцэд сайнаар болон муугаар илэрхийлсэн мэдээллүүд бүгд гарч ирэх жишээтэй.

Сонгуулийн сурталчилгааны хугацаанд фейсбүүк талбарт өдөрт дунджаар 34 (эхний долоо хоногт), 42 (сүүлийн долоо хоногт) мэдээлэл бүртгэгдлээ. Өөрөөр хэлбэл, сурталчилгааны сүүлийн долоо хоногт мэдээлэл/постын давтамж нэмэгдэв.



Сонгуулийн сурталчилгааны 15 хоногт нэр дэвшигчидтэй холбоотой 579 мэдээлэл/постыг бүртгэсэн бөгөөд хэрэглэгчид эдгээрт нийт 705,750

удаагийн хариу үйлдэл үзүүлжээ. Өөрөөр хэлбэл, нэг постод дунджаар 1218 хариу үйлдэл үзүүлсэн байна.





Фейсбүүк хэрэглэгчид хариу үйлдэл үзүүлэхдээ дэмжих, эсэргүүцэх, шоолох, гайхширах, уурлах, бусдад хуваалцах, санал сэтгэгдэл бичиж зэргээр олон янзын сэтгэл хөдлөлийг илэрхийлдэг.

Үүнээс сэтгэл хөдлөлөө илэрхийлэн эмож дарсан давтамж 260,559 удаа (37%), бусадтай хуваалцаж тоо 349,086 удаа (49%), санал сэтгэгдэл бичсэн тоо 96,105 удаа (14%) байна.



Дээрх графикаас харахад, Монголчууд фейсбүүкт хүний эрхийн зөрчлийг агуулсан байж болзошгүй мэдээлэл/постуудыг бусадтайгаа хуваалцаж цааш түгээх хандлага илүү байна. Тодруулбал, нийт хариу үйлдэл үзүүлсэн тохиолдлын тал хувь нь хуваалцах


байдлаар илэрчээ. Сэтгэгдэл бичих нь эмож дарах, шейр хийхээс харьцангуй бага байна.


Харин эмож дарж сэтгэл хөдлөлөө илэрхийлсэн байдлыг нарийвчлан харвал дараах байдлаар илэрчээ.

Нийт хариу үйлдлийн тоо	Эможийн тоо	Үүнээс like	Үүнээс love	Үүнээс care	Үүнээс haha	Үүнээс wow	Үүнээс sad	Үүнээс angry	Шейрын тоо	Сэтгэгдлийн тоо
705,750.00	260,559.00	178,481.00	20,745.00	8,659.00	22,906.00	1,152.00	7,998.00	20,618.00	349,086.00	96,105.00

Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчидтэй холбоотой мэдээлэл/постод фейсбүүк хэрэглэгчид дараах байдлаар сэтгэл хөдлөлөө илэрхийлжээ. Тухайлбал, нийт сэтгэл хөдлөлийн 68 хувьд

нь дарж дэмжсэн бол 9 хувьд дарж шоолсон байв. Харин уурлаж буюу эсэргүүцсэн нь 8 хувь байв.





Хариу үйлдлийн бүтцийг ажиглавал хоёр хариу үйлдлийн нэг нь бусадтай хуваалцаж цааш нь түгээдэг бол дөрвөн хариу үйлдэл тутмын нэг нь лайк дарж дэмждэг, арван хариу үйлдлийн нэгд нь санал сэтгэгдэл бичсэн байна. Хариу үйлдэл үзүүлж буй байдлыг сонгуулийн сурталчилгааны хоногоор

харьцуулж харвал сүүлийн 7 хоногт хуваалцаж түгээх давтамж нь багасаж, харин лайк дарж дэмжих, сэтгэгдэл бичих давтамж нэмэгджээ. Түүнчлэн angry буюу уурласан эмож, love буюу зүрх дарсан тохиолдол нэмэгдсэн байв.

Хамгийн олон удаа хариу үйлдэл авсан түгээмэл 20 постын тоон мэдээлэл

№	Сувгийн нэр /Аккаунт пэйж/ группын нэр	Тус аккаунт / пэйж группын дагагчдын тоо	Пост орсон огноо	Хариу үйлдлийн нийт тоо	Эможийн тоо	Шейрын тоо	Сэтгэгдлийн тоо
1	Trend news	16,919.00	5 сарын 27	125,858.00	3,758.00	120,000.00	2,100.00
2	Shuur	23,010.00	6 сарын 06	29,024.00	11,393.00	11,131.00	6,500.00
3	Zugii.mn	137,938.00	5 сарын 24	25,681.00	17,022.00	2,059.00	6,600.00
4	Zarig.mn	742,649.00	5 сарын 27	19,467.00	6,417.00	7,250.00	5,800.00
5	Focus.mn	21,798.00	5 сарын 26	17,672.00	4,616.00	10,456.00	2,600.00
6	Сэтгүүлч Н.Урантогтох	218,624.00	5 сарын 27	15,262.00	9,887.00	1,575.00	3,800.00
7	Монгол Ардын нам	99,100.00	5 сарын 27	14,032.00	3,868.00	7,783.00	2,381.00
8	Монгол Ардын нам	99,100.00	5 сарын 27	13,809.00	3,832.00	7,960.00	2,017.00
9	Монгол Ардын нам	99,100.00	5 сарын 26	12,078.00	3,943.00	5,894.00	2,241.00
10	Molpedia TV	332,644.00	6 сарын 06	11,224.00	9,944.00	720.00	560.00
11	Улаан бал	157,751.00	6 сарын 03	10,992.00	3,642.00	5,450.00	1,900.00
12	Монгол Ардын нам	99,100.00	6 сарын 05	10,182.00	4,969.00	3,913.00	1,300.00
13	Эмүжин	137,979.00	6 сарын 06	9,595.00	3,908.00	4,187.00	1,500.00
14	MGL Radio - Дэлхийн Монголчуудын Радио	622,638.00	5 сарын 30	9,168.00	3,741.00	4,854.00	573.00
15	Отгонбаяр Отгон	6,883.00	6 сарын 02	8,882.00	962.00	7,100.00	820.00
16	Sonin.mn	230,956.00	5 сарын 24	8,292.00	5,548.00	344.00	2,400.00
17	Uyanga Gantumur	122,422.00	5 сарын 27	7,521.00	4,962.00	1,059.00	1,500.00
18	Jargal Defacto	85,984.00	5 сарын 25	7,071.00	5,354.00	1,500.00	217.00



19	Энхтайваны Бат-Амгалан	32,262.00	5 сарын 25	6,584.00	4,687.00	929.00	968.00
20	Оросоогийн Түвшиндэмбэрэл	4,567.00	5 сарын 24	5,486.00	344.00	4,870.00	272.00

Дээрх хүснэгтээс харахад, фейсбүүк талбарт нөлөө бүхий пэйжүүдийг хэрэглэгчдээс хариу үйлдэл авсан тоогоор жагсаавал: 1) мэдээллийн сайтуудын пэйж хуудаснууд, 2) сэтгүүлч гэсэн тодотголтой, эсвэл

сэтгүүл зүйгээр танигдсан хүмүүс, 3) улс төрийн намын пэйж хуудас, 4) улс төрчид болон олны танил хүмүүсийн пост/мэдээлэл хамгийн олон хүнд хүрч, мөн хамгийн олон удаа хариу үйлдэл авчээ.

Жишээ нь: trend news, shuur, zugii.mn, zarig.mn гэсэн хуудаснуудаас гадна Сэтгүүлч Н.Урантогтох, Улаанбал, Эмүжин гэсэн аккаунтууд тэргүүлэх

үүрэгтэй оролцжээ. Улс төрч Uyanga Gantumur, Jargal Defacto зэрэг хүмүүсийн фейсбүүк хуудаснууд топ 20 жагсаалтад багтсан байна.



Хамгийн олон хариу үйлдэлтэй постуудын 70 хувь нь сонгуулийн сурталчилгааны эхний долоо хоногт фейсбүүкт нийтлэгджээ. Эдгээр нь нийт хариу үйлдлийн 52 хувийг эзэлж байна. Дээрх графикаас

харахад, хамгийн олон удаа хариу үйлдэл хүлээн авсан постуудад 57 хувь нь хуваалцах хэлбэрээр, 31 хувь нь эмож дарах байдлаар сэтгэл хөдлөлөө илэрхийлсэн, 13 хувь нь сэтгэгдэл бичих хэлбэрээр илэрчээ.

ХАМГИЙН ОЛОН УДАА ХАРИУ ҮЙЛДЭЛ АВСАН ТҮГЭЭМЭЛ 20 ПОСТЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

Мониторингийн хүрээнд бүртгэгдсэн давхардсан тоогоор 658 мэдээллийн 254 буюу 43.9% нь Зөв хүн электорат эвслээс нэр дэвшигч Д.Энхбатын тухай, 245 буюу 42.3% нь АН-аас нэр дэвшигч С.Эрдэнэтэй хамааралтай байсан бол үлдсэн 159 мэдээлэл буюу 27.5% нь МАН-аас нэр дэвшигч У.Хүрэлсүхтэй холбоотой мэдээлэл байв. Энд хүний эрхийн зөрчил

агуулсан, эс агуулснаас үл хамааран цахим хайлтын үр дүнд илэрсэн мэдээллүүдээс хувиар илэрхийлсэн болно. Жишээ нь: Хүүкээ дэмжинэ, элит сонголт хийхийг дэмжиж байна, боловсрол хамгийн эхэнд гэх зэргээр нэр дэвшигчдийн уриатай холбоотой мэдээллүүд ч багтана.





Эндээс харахад, сонгуулийн сурталчилгааны хугацаанд нэр дэвшигч Д.Энхбат болон С.Эрдэнэ нарын талаарх мэдээлэл фейсбүүк талбарт зонхилж байв.

Харин сонгуулийн сурталчилгааны хугацаанд хамгийн олон удаа хариу үйлдэл авсан постуудын дийлэнх олонх нь буюу 75 хувь нэр дэвшигч У.Хүрэлсүх, 20 хувь нь нэр дэвшигч Д.Энхбат, үлдсэн 5 хувь нь нэр дэвшигч С.Эрдэнэтэй холбогдож байв.



Өөрөөр хэлбэл, сонгуулийн сурталчилгааны хугацаанд АН-аас нэр дэвшигч С.Эрдэнийн тухай мэдээлэл нийт постын 42,3 хувьд нийтлэгдсэн боловч сонгогчдоос дэмжлэг аваагүй, ярианы сэдэв болж өрнөөгүй (5%) харагдана. Харин МАН-аас нэр дэвшигч У.Хүрэлсүхийн талаар өрсөлдөгчидтэйгөө харьцуулбал хоёр дахин бага мэдээлэл/пост цацагдсан ч ярианы сэдэв болохын хувьд олон нийтийн дунд ихээхэн (75%) хэлэлцүүлэгт орсон харагдана.

Сонгуулийн сурталчилгааны хугацаанд фейсбүүк талбарт нийтлэгдсэн нэр дэвшигчидтэй холбоотой хоёр мэдээллийн нэг нь эерэг хандлагатай байсан бол гурван мэдээллийн нэг нь сөрөг агуулгатайгаар нийтлэгджээ.

Гэвч эдгээр нь сурталчилгааны эхэн ба төгсгөл үед өөрчлөгдсөн юм.



Сурталчилгааны сүүлийн 7 хоногт эерэг, сөрөг хандлагатай туйлширсан мэдээлэл аль аль нь өсөв. Тодруулбал, сүүлийн 7 хоногт эерэг мэдээллийн давтамж 32%, сөрөг мэдээллийн давтамж 16% тус тус өссөн. Сурталчилгааны эхэн үед төвийг сахисан мэдээллүүд зонхилж байснаа төгсгөл үед аль нэг талыг барьсан “туйлширсан” мэдээлэл зонхилов.



Нэр дэвшигч тус бүрээр харьцуулан харвал, сонгуулийн сурталчилгааны хугацаанд фейсбүүк талбарт АН-аас нэр дэвшигч С.Эрдэнийн тухай хамгийн олон эерэг (72.2%) мэдээлэл цацагдсан бол МАН-аас нэр дэвшигч У.Хүрэлсүхийн тухай сөрөг (45.3%) мэдээлэл зонхилов.

Сонгуулийн сурталчилгааны хугацаанд фейсбүүк хэрэглэгчид эерэг мэдээллээс илүү сөрөг мэдээллийг шейр хийж бусдад дамжуулах нь бусад хариу үйлдлээсээ хоёр дахин их байгааг мониторингоор

тогтоолоо. Харин сөрөг мэдээллээс илүү эерэг мэдээллийг лайк дарж дэмжих нь гурав дахин их байгаа нь дараах графикаас харагдаж байна.



Сонгогчид фейсбүүк талбарт үзэл бодлоо илэрхийлэхдээ түйлшрэх буюу хэт нэг талыг дэмжих, эсвэл үгүйсгэх хандлага сурталчилгааны төгсгөл үед эрчимтэй нэмэгдэж буйг дээр дурдсан. Харин сөрөг агуулгатай мэдээллийг бусдад дамжуулж улам бүр түгээх, дэвэргэх хандлага нийтлэг ажиглагдав.



Фейсбүүк талбарт сонгогчдод нөлөө үзүүлэх зорилготой мэдээлэлд дийлэнхдээ зураг, дүрс ашиглаж байна.

Энэхүү графикаас харахад, хоёр мэдээлэл тутмын нэг нь зураг дүрстэй, гурван мэдээлэл тутмын нэг нь видеотой, арван мэдээлэл тутмын нэг нь ямар нэгэн холбоос линктэй байна.



Мэдээллийн хэлбэрийг сонгуулийн сурталчилгааны хоногоор харьцуулахад сурталчилгааны сүүлийн

долоо хоногт видео хэлбэрийн мэдээллийн давтамж 6 хувиар өссөн байна.



2.2 Фейсбүүкийн пост болон сэтгэгдэл хэсэг дэх хүний эрхийн зөрчлүүд

Монгол улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор хүнлэг энэрэнгүй байх, шударга, алагчлалгүй байх, хүний жам ёсны эрхэд хүндэтгэлтэй хандах, Жендерийн эрх тэгш байдлыг хангах, ялгаварлалгүй хандах зэргээр хүний суурь эрхүүдийг хамгаалдаг.

Мониторингд хамруулсан сонгуулийн сурталчилгааны 15 өдөрт тодорхой түлхүүр үгсээр хайлт хийхэд нийт 579 пост/мэдээлэл бүртгэснээс 28,6 хувь нь сөрөг агуулгатай мэдээлэл байв. Эдгээрээс сөрөг сэтгэгдэл агуулсан, хүний эрхийн зөрчилтэй гэж үзсэн нийт 207 пост/мэдээллийг мониторингийн багийнхан түүвэрлэн авч, нарийвчилсан дүн шинжилгээ хийлээ.

Сөрөг агуулгатай мэдээлэлд нэр хоч өгсөн, шоолж доромжилсон, ялгаварлан гадуурхсан, өдөөн турхирсан, үзэн ядах үг хэллэг ашигласан мэдээлэл/пост болон сэтгэгдлүүдийг бүртгэсэн болно.

Эдгээр мэдээлэл/пост, сэтгэгдэл нь үзэн ядалтын үг хэллэг ашигласан, нэр дэвшигчдийг гутаан доромжилсон, үймээн самуунд уриалсан үг хэллэгийг агуулсан хэмээн мониторингийн багийнхан онцлон бүртгэжээ.

Монгол улсын Үндсэн хуульд зааснаар иргэн бүр дараах эрхүүдийг баталгаатай эдэлнэ. Үүнд:

14.2 Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна;

16.11 Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй;

16.16 итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх,

тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;

17.2 хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

Түүнчлэн Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын өмнөтгөлд Монгол улсын Үндсэн хуульд заасан үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхийг хамгаалан бататгаж, Монголын сэтгүүл зүйн хэм хэмжээ нь олон улсын нийтлэг хэм хэмжээг сахин мөрдөж буйг энэхүү ёс зүйн зарчмаар илэрхийлж байна хэмээдэг.

Тиймээс сөрөг агуулгатай мэдээлэл/постоос 11 жишээг онцлон авч мэргэжлийн хуульч судлаачаар дүн шинжилгээ хийлгэн эрх зүйн талаас хүний эрхийн ямар зөрчил агуулж буйг тайлбар хийлгэснийг 3 дахь бүлгээс танилцана уу.

Фейсбүүкийн постоос гадна сэтгэгдэл хэсэгт үзэн ядалтын үг хэллэг түгээмэл ажиглагдсан тул мониторингийн баг нэмэлт ажиглалтыг хийсэн билээ. Учир нь Кудос-медиа мониторингийн систем нь ашиглалтын хугацаанаас хамааран сэтгэгдэл (comment) хэсгээс хайлт хийх техникийн боломж олгоогүй тул хайлтын системээр илэрсэн постуудын доорх сэтгэгдэл нэг бүрийг уншиж танилцан, хүний эрхийн зөрчил агуулсан сэтгэгдлүүдийг бүртгэж нэгтгэн боловсруулав.


Сэтгэгдэл хэсэгт хийсэн мониторингоор 207 сөрөг сэтгэгдэлтэй постын нийт санал сэтгэгдлийн тоо 174,503 байв. Эдгээр сэтгэгдлээс зөвхөн сөрөг сэтгэгдлүүдийг бүртгэж агуулгыг ангилж чанарын анализ хийлээ. Сэтгэгдлийн агуулгыг ангилахдаа постын агуулгатай нэгэн адилаар үзэн ядалтын үг хэллэг ашигласан, гутаан доромжилсон, үймээн самуунд уриалсан үг хэллэгийн давтамж тоогоор илэрхийлэв.



Фейсбүүкийн сэтгэгдэл хэсэг дэх хүний эрхийн зөрчил агуулсан үг хэллэгийн давтамж /тоогоор

Үзэн ядалтын үг хэллэг ашигласан, гутаан доромжилсон, үймээн самуунд уриалсан үг хэллэгтэй сэтгэгдлийн давтамж	
Хэлбэрүүд	Тоо/давтамж
Нэр, хоч өгсөн	76.00
Ажил мэргэжил, албан тушаал	1.00
Үндэс угсаа	14.00
Хэл	-
Нас, хүйс, арьсны өнгө	6.00
Нийгмийн гарал	5.00
Шашин шүтлэг	2.00
Хөрөнгө чинээ	-
Бусад	13.00
Нийт	119.00

Зарим жишээг, зургаар харуулбал:



Эндээс харахад, фейсбүүкийн сэтгэгдэл хэсэгт нийтлэгдсэн хүний эрхийн зөрчилтэй 119 постын 76 (64%) нь нэр дэвшигчдийг гутаан доромжилсон нэр, хоч өгсөн явдал байв. Жишээ нь: хулгайч өвгөн, мэлхий Эрдэнэ, луйварчин, арчаагүй тоть, гурилсүг

янхан гэх мэт үг хэллэг агуулжээ.

Сонгуулийн сурталчилгааны хугацаанд нэр дэвшигчдэд үзэн ядсан, ялгаварлан гадуурхсан нэр, хоч өгч “цоллох” явдал түгээмэл ажиглагдав. Эдгээрийг нарийвчлан харуулбал:

Агуулгын ангилал	Жишээ /үг хэллэг	Тоо/ давтамж
Нэр, хоч өгсөн	Худалч, худалдлагдсан худалч, арчаагүй урвагч, хулгайч, сагсуу хулгайч,хувалз, луйварчин, урвагч, гадны гар хөл, гадны хүүхэлдэй,барууны тэжээвэр, тэжээвэр, Элбэгдоржийн тэжээвэр, утсан хүүхэлдэй, тэжээвэр мууд тэжээвэр гөлөг,ялтан, алуурчин hvvk ноход, нохой, бах ногоон мэлхий, Гахай, новш, новшийн сүгнүүд, бузар новш, Засгийн зулбасга, Соросын тавиул, Сү-гийн уяаны нохой, Сү-н бууны нохой, аархуу, хонины арьс нөмөрсөн чоно, Хулхисүх, Түгжилсүх, Дүнхүү Хүүк, Дүлзэн Хүрэлсүг, Мянгуужин Хүрэлсүх, Хужаагийн Янхансүх, Алуурчин Хүүк, хулхи Хуранлаа, Бадарчин, бөөс, бэртэгчин, мэлхий шиг хавдар, мэлхий Эрдэнэ, гажиг, гахай, намын тогой, хутган үймүүлж, хагалан бутаргагч, лалараа, пизда, МАНАН Мафийн толгойлогч Элбэгдорж, бэртэгчин, идэж ханадаггүй Багабанди, улсаа худалдагч Очирбат, шээс нь гоожиж байгаа хаусчин Санжийн Баяр,бөлдөгчин генерал Хурц, Эх орноосоо урвагч, Дубай нэртэй Сайханбилэг, Ноомоо, доожоогүй, Пялдага, Сармагчин шиг хүн дуурайх өвчтэй, тоть, янхан, төлөг, эргүү, уймраа, мангар, бөгс долоогч, луйварчдын гар хөл	76.00



Ажил мэргэжил, албан тушаал	Монгол хүн монголоор мэндчилэх, казак хүн жолоо атгаж чадах уу, урианхай, хасаг, хужаа шиг, хужаа цустай, эрлийз, хятад, хужаа, монгол биш хужаа, Элит хужаа, Элбэгдорж хужаа, данжаадын шээс, хужаагийн тагнуул, хужаагын гар хөл гм	1.00
Үндэс угсаа	Хөгшин, тэтгэврийн өвгөн, өвгөн, өвөө, өвгөн	14.00
Хэл	N.A	-
Нас, хүйс, арьсны өнгө	Хөгшин, тэтгэврийн өвгөн, өвгөн, өвөө, өвгөн	6.00
Нийгмийн гарал	Элит	5.00
Шашин шүтлэг	Христ номлол	200
Гэр бүлийн байдал	Олон хүүхэнтэй, single mom	200
Хөрөнгө чинээ	N.A	-
Бусад	Ялтан, хатгуурчин, гадааджуу үзэл ард түмний амь насанд хохирол учруулаад зугтсан өвөө минь, Бавдаг хүүхэн, Осоржамаа байсан ч яахав, хүн алсан, шоронд суух ёстой, неолибизм гэж худал гүтгэсэн гм	13.00
Нийт		119.00

Нэмэлт тайлбар: N.A - Мэдээлэл байхгүй, мэдээлэл бүртгэгдээгүй

Үзэн ядалтын үг хэллэг ашигласан, гутаан доромжилсон, үймээн самуунд уриалах зэргээр хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөний зөрчил агуулсан постуудын зарим жишээ

1. https://www.facebook.com/permalink.php?story_fbid=174961407963770&id=100063497347489

Сошиализм & Socializm

Intro

3.2K Followers

Page · Personal Blog


Not yet rated (0 Reviews)

Photos
[See All Photos](#)


ХҮН МАНГАСЫН дарангуйлалгүй болохын төлөө зүтгэнэ. Бид нар 1990 онд ардчилсан хувьсгалыг оготнын хамраас ч цус гаргалгүй хийж байхад Д. Энхбат хаана байсан юм. Статистикийн газар нэг муу хурга дарга байсан юм байгаа биз. Сандалдаа шигдээд сууж байхад нь бид ардчиллын төлөө тэмцэж байсан юм. Бид ардчиллыг авч ирсэн болохоос бэртэгчин Д. Энхбатын эзэн Соросоос худалдаж аваагүй. "Танай Монголын Ардчиллыг чинь та нарт худалдаад аваад өгчихсөн шүү дээ. Танай ардчиллын мөнгө төлөгдсөн" гэж тэр Сорос нь хэлсэн гэсэн. Ардчилсан нам байгаа цагт ардчиллыг өмөөрөх л болно. Тэр тусмаа 7-р сарын 1-ныг удирдан зохион байгуулчхаад зугтаж, эхнэрийнхээ хормойд нуугдсан бэртэгчин сэхээтнээс ардчиллаа хамгаалж ХҮН МАНГАС-ын дарангуйлалгүй, ардчилсан Монголын төлөө тэмцэнэ. Олон түмэнд хэрэгтэй цагт оготнын нүхэнд нуугдчихаад олон долоон юм ярьж ардчиллыг серж дэвшинэ гэж байхгүй шүү.




2. <https://www.facebook.com/khuchirkhegmongol/posts/1693169120884712>



3. https://www.facebook.com/permalink.php?story_fbid=116401013907187&id=100066118669167




4. <https://www.facebook.com/dmnegdel/posts/3134139740198648>





Түүнчлэн нийгмийн хэвлэл мэдээлэлд олон дагагчтай нөлөөлөгчдийн (social influencers) фейсбүүк постын дор сөрөг агуулгатай, хүний эрхийн ноцтой зөрчил

агуулсан сэтгэгдлүүд олноор бүртгэгдэж байв. Жишээ нь: Сэтгүүлч Эмүжиний постын дорх сэтгэгдлүүдээс:



Троллингоор дамжуулан цахим орчинд ялангуяа фейсбүүкт сонгогчдын тархи угаах, мэдээллийг мушгин гуйвуулах үйл ажиллагаа явуулж буй байдлыг мониторингийн хүрээнд тандахыг зорилоо. Учир нь цахим орчинд троллингоор дамжуулан тархи

угаахдаа хүний үндсэн эрхийг зөрчих, улс төрийн өрсөлдөгчийг гутаан доромжлох, эсрэг буюу ялгаатай үзэл бодлыг хаах байдлаар нийгэм дэх мэдээллийг хянаж байдаг.

2.3 Троллинг буюу “Цахим цэрэг”-ийн урсгал

Иймээс мониторингийн багийнхан постуудын дор нийтлэгдсэн сэтгэгдэл хэсэгт нэг ижил агуулгатай үг, өгүүлбэр олон дахин давтагдах, хэт нэг талыг барьсан ижил агуулгатай мэдээллүүдийг тусад нь бүртгэл

хөтөлсөн юм.

Тухайн сэтгэгдлүүдийг сонгохдоо тус мониторингийн хүрээнд бүртгэгдсэн хүний эрхийн зөрчилтэй постууд болон хамгийн их хариу үйлдэлтэй постуудын сөрөг



сэтгэгдлүүдээс агуулгын давтамжаар нь сонгон авсан болно. Эерэг сэтгэгдлүүдийн агуулга нь “Дэмжиж байна”, “Амжилт хүсье”, “Дарангуйлалгүй Монголын төлөө”, “Ардчиллаа аваръя”, “Баялагтаа эзэн болцгооё”, “Баялагтаа эзэн Монгол”, “Бид чадна”, “Монголчууд чадна”, “Монгол чадна” гэх мэт нэр дэвшигчдийн сонгуулийн кампанит ажлын уриа үгээр илэрхийлэгдэж байв. Өөрөөр хэлбэл, сонгуульд

нэр дэвшигчдийг дэмжсэн тэдний уриа үгийг тогтмол постлох зорилго бүхий троллинг багууд ажиллаж байв.

Үүний зэрэгцээ нэр дэвшигчдийг гутаан доромжлох, ялгаварлан гадуурхсан нэр хоч бүхий мессэжийг давтан явуулах, сөрөг мэдээллийг ятгуулан үнэмшүүлэх зорилготой мэдээлэл цацагдаж байв. Жишээ нь:

Нэр дэвшигч Д.Энхбатыг “Хонины арьс нөмөрсөн чоно” хэмээн цоллов.



Altaiyuu Huiagsaihan
Хонины арьс нөмөрсөн чоно байжээ. Итгэх итгэл 0%

Like · Reply · 2d

1 Reply



Anujin Dashvandan
Итгэл даахаар хүн биш юмдаа.

Like · Reply · 23h



С. Сэкий
Хонины арьс нөмөрсөн чоно байжээ

Like · Reply · 2d



Э. Цэцэг
Ийм хүн яаж улс орон удирдаж чадах вэ дээ. Монгол ялна чадна гээл бсан. Арайчдээ хонины арьс нөмөрсөн чоно байжээ

Like · Reply · 2d · Edited



NM Bat
Хонины арьс нөмөрсөн, гэмгүй царайлсан нөхөр гэдэг үнэн дээ... Ёстой зөв - Монгол хүн бүтээж чадна...

Like · Reply · 1d

Нэр дэвшигч У.Хүрэлсүхийг “Хүүк, Гүрилсүг, Дүлзэн Хүрэлсүх, Хүүрэнсүг, Түгжил, Донтон, дарангуйлагч,

ялтан, алуурчин, луйварчин, хулгайч, сагсуу, урвагч” зэргээр нэр хоч өгч, үзэн ядав.



Saagii Hulan
Цагаан хэл ам болоод угаартаж үхээсэй гэж ерөөе УЛС ОРНОО ХУДАЛДСАН ХҮН ШААР СУ.БАТБОЛДТОЙГОО ХАМТ МАРТЧИХАЖ КАПИТАЛ БАНКНЫ УНДАРМАА БАС

Like · Reply · 1d



Erdenebat Gombo
Мүү ЭХ ОРНООСОО УРВАГЧ ЛУЙВАРЧИН ИЙМ ХҮН ЯАЖ ЕРӨНХИЙЛӨГЧ БОЛОХ ЮМ БЭ !!!!!
ХАРИН ЯЛ АСУУХ ЁСТОЙ!!!!
Ардын намыг татан буулгах ёстой!!!

Like · Reply · 1d · Edited



Khan Choi
Луувирчин дагаж хуулирч гүйгээд яана даа

Like · Reply · 1d



Mandah Dash
Энэ нэг л хойд Солонгосын дүр зураг нүдэнд харагдаад байх юм ,Жүжиг л тавиад байх шиг ,

Like · Reply · 1d

Нэр дэвшигч С.Эрдэнийг “Мэлхий, бах, гахай, нохой, алуурчин, хувалз, хулгайч, луйварчин” хэмээн доромжлов.



Shagai Bayar
Гахай 🐷 С.Эрдэнэ шудрага өрсөлд. Өрсөлдөгчөө харлуулах чинь таалагдахгүй байна, чам шиг хэрүүлч, хэрүүлийн бузар хүнийг Ерөнхийлөгчөөр сонгохгүй 🙄
🙄 Гадаадад гацсан иргэдээ “Вирус” гэж хуцаа биз дээ 🙄 Өөрөө хийсэн ажил, хэлэх үггүй болохоор хүний хи... See More

Like · Reply · 13h · Edited



Togtohbayr Legjmaa
Зайл аа ..новшийн юм бэ ..хорлон сүйтгэсээр л ..

Like · Reply · 13h



Oyun Erdene
Энэ бахыг хэн тоож сонгохов дээ

Like · Reply · 12h



ГУРАВ. СОНГУУЛИЙН ҮЕЭР ЦАХИМ ОРЧИНД НИЙТЭЛСЭН МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГА ДАХЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ЗӨРЧСӨН ТОХИОЛДЛУУДАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

3.1 Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч У.Хүрэлсүхтэй холбоотой тохиолдлын дүн шинжилгээ

МЭДЭЭЛЭЛ, НИЙТЛЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ:

“Хатуу мэдээ” гэх нэртэй фейсбүүкийн хуудаст 2021.05.24-ний өдрийн 19:27 цагт оруулсан зураг, түүний тайлбарт нэр дэвшигч У.Хүрэлсүхийг шүүмжлэх нэрийн дор сонгуулийн хууль тогтоомж болон хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн шинжтэй агуулга тусгагджээ. Тодруулбал, “Ухнаагийн Хүрэлсүх – Монгол Улсын төлөө зүтгэе! Баялагтаа эзэн Монгол” гэх уриа үгийг үргэлжлүүлж “Баялагтаа эзэн Монгол би Батцэцэгт 592 сая төгрөгийг өгөв...”,

“Түүний сонгуулийн уриа нь ‘Баялагтаа эзэн Монгол’. Түүний шударга ёсны хэмжүүр нь Хүүхэнд 592 сая төгрөг бэлэглэдэг, нууц амрагтаа 2 байр бэлэглэдэг, Н.Ундармаад 395 тэрбум төгрөг завшуулдаг, Сү.Батболдын 1 их наядын хулгайг хамгаалдаг...” гэжээ. Мөн тус зурагт нэр дэвшигч У.Хүрэлсүх, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгийн зураг, “Улаан бал” нэвтрүүлэг оролцсон Б.Сүндэръяагийн зургийг оруулжээ.





Мөн тус зургийн тайлбарт “У.Хүрэлсүхийн уриа нь их гоё юм. “Баялагтаа эзэн Монгол” хэмээх уриатайгаар тэр хүн сонгуульдаж байгаа ажээ... Гэвч Монголын баялагт сүүх эзэн нь хэн билээ. Лав би биш. Тэгэхээр та ч бас биш... Харин Монголын баялгийг түүний ойр тойрны авгай хүүхнүүд эзэгнэх байх гэвэл дөхөж очно...

- Түүний нууц амраг Төсвийн мөнгөөр 2 байр авч, ээж авга ахдаа бэлэглэн, Төрийн хамгаалалтанд жаргаж, адууны жүчээ хэсэн тансаглаж явдаг...

- Түүний казинод дагуулж явдаг хүүхэн, Төрийн Сайдын суудалд заларч, Татварын мөнгөнөөс 562 сая төгрөг хүртэн жаргаж суудаг...

- Түүний хамтран дүүлдаг Ундармаа авгай татвар төлөгчдийн мөнгийг самарч Төрийн хуулиас гадуур зугаалж явдаг...

- Түүний эзэн Сү.Батболд улсаас минь хулгайлсан 1 их наяд төгрөгөө хураалгахгүйн тулд Засаг унагаан Төр эргүүлдэг...

Харин түүний хийдэг ажил нь тэр бүхнийг хамгаалан хаацайлж хир халдаахгүй байх явдал юм...

Тэгэхээр “Баялагтаа эзэн Монгол” гэдэг уриа нь яг хэнд зориулагдсан үг билээ?

Иргэн танд Б.Батцэцэгт сарвайсан шиг 592 сая төгрөг сарвайна гэж бодож байна уу?

Энэ чинь л асуудал юм...

Төрийн мөнгөөр элдвийн эмсэд тал зассан түүний шударга ёсны хэмжүүрийн зөвхөн “Үзүүр” нь энэ...

“Солонгост хар ажил хийдэг эгч нь түүнд 2 тэрбум төгрөг явуулсан” гэж ичихгүй залдаг хүн шүү дээ...

Яг одоо ингэхэд хэн нь “Баялагт маань эзэн Монгол” болох гээд байна вэ?

Бодогтун!” гэжээ.

ЗӨРЧЛИЙН ШИНЖ БАЙДАЛ:

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлийн 1-т “Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй”, 2-т “Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана” гэж, 3-т “Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараах шаардлагаас үүдэн гарсан байх ёстой: а/ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх; б/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах” гэж тус тус заасан.

Тодруулбал, нэр дэвшигч У.Хүрэлсүх, түүний мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны талаар үзэл бодлоо цахим орчинд чөлөөтэй илэрхийлэх эрхтэй хэдий ч

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлийн 3-т заасны дагуу тийнхүү илэрхийлэхдээ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх; үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахуунд харшлахгүй байх ёстой.

Дээрх нийтлэлд дурдсан “Хүүхэнд 592 сая төгрөг бэлэглэдэг, нууц амрагтаа 2 байр бэлэглэдэг, Н.Ундармаад 395 тэрбум төгрөг завшуулдаг, Сү.Батболдын 1 их наядын хулгайг хамгаалдаг” гэх мэдээлэл нь нэр дэвшигч У.Хүрэлсүхэд шууд хамааралтай, бодитой гэдгийг нотлоогүй, тухайн мэдээллийн холбогдох эх сурвалжийг дурдаагүй байна. Түүнчлэн, “хүүхэн, нууц амраг, авгай, элдвийн эмс” гэх үгсийг доромж утгаар хэрэглэсэн байх бөгөөд энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т хүнийг нас, хүйсээр нь ялгаварлан гадуурхаж үл болно гэснийг зөрчсөн байна.

ЗӨРЧЛИЙН МӨРӨӨР АВАХ АРГА ХЭМЖЭЭ:

Нэр дэвшигч У.Хүрэлсүх, түүний багийн зүгээс дээрх нийтлэлд дурдсан агуулгыг албан ёсоор бодит эх сурвалж, бүрэн мэдээллийг олон нийтэд танилцуулж няцаах ёстой. Тийнхүү няцаагаагүй бол тухайн нийтлэлийн агуулгыг олон нийтийн зүгээс үнэн гэж ойлгоход хүрэх юм.

Нэр дэвшигч У.Хүрэлсүхийн хувьд Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйл /Сонгуулийн хуулийг

зөрчих/-ийн 7-д нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд тараасан нь зөрчил болох, Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйл /Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах/-ийн 1-т сонгуульд оролцогч нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан нь гэмт хэрэг болохоор тус тус заасны дагуу цагдаагийн байгууллагад гомдол гаргах эрхтэй.



Мөн тухайн нийтлэлд нэр, дүрс нь орсон Б.Батцэцэг, Н.Ундармаа, Сү.Батболд, Б.Сүндэръяагийн хувьд дээрх нийтлэлд дурдсан агуулгыг албан ёсоор бодит эх сурвалж, бүрэн мэдээллийг олон нийтэд танилцуулж няцаах ёстой бөгөөд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл /Худал мэдээлэл тараах/-ийн 1-т хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол гэмт хэрэг болохоор заасны дагуу цагдаагийн байгууллагад гомдол гаргах эрхтэй.

Гэхдээ дээрх нийтлэлд нэр, дүрс нь орсон хүмүүсийн хувьд олон нийтийн хяналтад байдаг, сонгогдсон албан тушаалтнууд болохын хувьд цагдаагийн байгууллагад гомдол гаргахаас илүүтэйгээр бодит, бүрэн мэдээллийг олон нийтэд өгч буруу ойлголт үүсэхээс сэргийлэх нь илүү оновчтой юм. Түүнчлэн, дээрх нийтлэлийг түгээсэн цахим хуудсын хувьд мэдээллийн эх сурвалжаа оруулах, ялгаварлан

гадуурхсан агуулгаас зайлсхийх замаар Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээх эрсдэлээс сэргийлэх нь зүйтэй.

Түүнчлэн, дээрх нийтлэл нь Сонгуулийн Ерөнхий Хорооны 2020.04.14-ний өдрийн 21 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам”-д шууд хамаарахгүй тул Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны 2011 оны 08 тоот тогтоолын хавсралт “Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-ын дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтны дүгнэлт, шийдвэрийг үндэслэн Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос тухайн нийтлэл бэлтгэсэн этгээдэд шаардлага тавих, зөрчлийг арилгах буюу хандалтыг хязгаарлах техникийн арга хэмжээ авч болох юм.

3.2 Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч С.Эрдэнэтэй холбоотой тохиолдлын дүн шинжилгээ

МЭДЭЭЛЭЛ, НИЙТЛЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ:



“Хар дэвтэр” гэх нэртэй фейсбүүк хуудаст 2021.05.26-ны өдрийн 01:25 цагт оруулсан “С.Эрдэнийн түүх” гэх нийтлэлд нэр дэвшигч С.Эрдэнийн сонгуулийн сурталчилгааны самбарын зургийн өмнө байрлах хогийн савны нүүр хэсэгт “Аллага, авлигын хэргээр ял сонсож байсан эрүүгийн хулгарт төрийн тэргүүний сэнтий ахдана” гэж бичсэн зургийг хавсаргажээ. Тухайн нийтлэлд “1984 онд хүний амь хохироосон хэргээр ял авч, ялаа шоронд эдэлсэн нэгэн. ... 2009 оны нэгдүгээр сар. Тухайн үед Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргаар ажиллаж байсан найман хүний хамт Баянгол дүүргийн шүүхээс ял авсан үнэн. ... Гэсэн ч Ерөнхийлөгчийн сонгуульд Ц.Элбэгдорж ялалт байгуулснаар тэд бүгд хамтдаа шоронгоос суллагдаж, гэмт хэргийнх нь түүх дуусгавар болсон байдаг. Гэхдээ л бодит үнэн нь С.Эрдэнэ хоёр дахь удаагаа ял авсан, нийгмийн даатгалын мөнгийг өөрийнхөө хувийн эрх ашгийн төлөө урвуулан ашигласан нь нотлогдсон түүх нь үнэн юм. ...” гэжээ.



ЗӨРЧЛИЙН ШИНЖ БАЙДАЛ:

Дээр нийтлэл нь С.Эрдэнэ нэр дэвших эрхгүй буюу нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангахгүй гэх агуулгыг илэрхийлж байна. Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 26.5-д “Эрүүгийн гэмт хэрэг үйлдэж шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор ял эдэлж байгаа хүн нэр дэвшихийг хориглоно” гэж заасан бөгөөд нэгэнт ялгүй болсон хүнийг ял эдэлж байгаа хүнтэй адилтгах боломжгүй юм. Ял шийтгүүлсэн үйл баримтаар нэр дэвшигчийг ялгаварлах нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т “Хүнийг ... нийгмийн гарал, байдал, эрхэлсэн ажил, албан тушаал,...-р нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэснийг зөрчсөн шинжтэй байна.

Мөн Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 26.6-д “Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно” гэж, энэ талаарх лавлагааг тус хуулийн 28.2.15-д зааснаар Цагдаагийн ерөнхий газрын мэдээллийн

сан хариуцсан нэгжийн лавлагаагаар тодорхойлно. Сонгуулийн Ерөнхий Хорооноос С.Эрдэнийг авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон бол түүнийг нэр дэвшигчээр бүртгэхгүй байсан. Түүнчлэн дээрх нийтлэлд шүүхийн шийдвэрийн талаарх мэдээлэл байхгүй, Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн зүгээс С.Эрдэнэд уучлал үзүүлсэн эсэх талаар тодорхой дурдаагүй байна. Тодруулбал, энэ нийтлэл нь Иргэний хуулийн 21.3-т заасан бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс бусдын нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан шинжтэй зөрчил байх бөгөөд Иргэний хуулийн 21.2-т зааснаар иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ.

ЗӨРЧЛИЙН МӨРӨӨР АВАХ АРГА ХЭМЖЭЭ:

Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 5.6-д “...сонгогчоос саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хөндлөнгөөс нөлөөлөх, саад учруулахыг хориглоно” гэж заасан бөгөөд дээрх нийтлэл нь нэр дэвшигчийн талаарх саналаа илэрхийлсэн агуулгатай байх тул тухайн нийтлэл бичсэн этгээдийн талаар гомдол гаргах нь зохисгүй юм. Харин дээрх нийтлэлтэй

холбоотой бодит буюу нэр дэвшигчийн нэр хүндийг хамгаалахад чиглэсэн баримтыг нэр дэвшигч С.Эрдэнэ, түүний баг сонгогчдод хандан мэдээлэх нь зүйтэй юм. Энэ хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагааг сонгогчдод нээлттэй танилцуулах шаардлагатай.



3.3 Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Д.Энхбаттай холбоотой тохиолдлын дүн шинжилгээ



2021 оны тавдугаар сарын 29-ний өдөр 15:25 цагт “DMNN” гэх нэртэй фейсбүүкийн хуудаст “Анхаараарай! Ж.Соросын гар хөл бологч, Монголоос урвагч нар сонгуулийн үр дүнг зөвшөөрөхгүй хэмээн 07.01-ийг давах гэж оролдох бий” гэсэн бичвэртэй нэр дэвшигч Д.Энхбатыг Жорж Соросын утсан хүүхэлдэй болсон мэтээр илэрхийлсэн зураг хавсаргасан нийтлэл оруулжээ. Энэхүү нийтлэл “7 сарын 1-ийг зохион байгуулж байсан гадны Ж.Соросын гар хөл Д.Энхбат дахин мөргөлдөөнийг давах вий!!!! Жорж Соросын гар хөлийг Ерөнхийлөгчөөр сонгоцгоох уу!” гэж эхэлсэн байх бөгөөд Ж.Соросыг өнгөт хувьсгалд буруутгасан, “Соросын Сан Монголд гэнэт идэвхижиж, Нээлттэй нийгэм хэмээх форумыг санхүүжүүлж, Д.Энхбат гол дүрээр нь тодорч эхлэв. Удалгүй иргэний нийгмийн хөдөлгөөн байгуулагдаж, жагсаал цуглаан идэвхижиж, Д.Энхбат 2008 онд УИХ-д сонгогдлоо” гэх зэргээр нэр дэвшигч Д.Энхбатыг Жорж Соростой хамсаатан мэтээр тайлбарлажээ.

Энэхүү нийтлэл, хавсралт зураг нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлийн 3-т заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхдээ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх, нийгмийн дэг журам, ёс суртахуунд харшлахгүй байх ёстой гэснийг зөрчсөн байна. Түүнчлэн тухайн нийтлэлд эх сурвалж, бодит баримт дурдаагүй бөгөөд Иргэний хуулийн 21.3-т заасан бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс бусдын нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан шинжтэй зөрчил байна.

Нэр дэвшигч Д.Энхбатын хувьд Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйл /Сонгуулийн хуулийг зөрчих/-ийн 7-д нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд тараасан нь зөрчил болох, Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйл /Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах/-ийн 1-т сонгуульд оролцогч нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан нь гэмт хэрэг болохоор тус тус заасны дагуу цагдаагийн байгууллагад гомдол гаргах эрхтэй. Мөн Иргэний хуулийн 21.2-т зааснаар иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл,

эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ.

Иргэний хуулийн 21.6-д “Иргэний нийгэмд эзлэх байр суурьтай холбогдуулан түүнийг сурталчлах зорилгоор болон сургалт, эрдэм шинжилгээний ажил, ажил хэргийн хүрээнд олон нийтийг хамарсан үйл ажиллагааны явцад уг этгээдийг дүрсэлсэн, эсхүл тухайн этгээд өөрийгөө дүрслүүлсний төлөө хөлс, шан харамж авсан бол түүний зөвшөөрөл шаардагдахгүй” гэж заасан бөгөөд дээрх нийтлэлд холбогдох зургийг хавсаргахдаа нэр дэвшигч Д.Энхбатын зургийг гутаан доромжлох байдлаар оруулсан байх тул Иргэний хуулийн 21.5-д зааснаар иргэний дүрсийг гэрэл зураг болон бусад хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлсэн, олон нийтэд үзүүлснээс гэм хор учирсан гэж үзвэл тухайн этгээд гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй. Гэхдээ дээрх нийтлэлд дүрс нь орсон Д.Энхбатын хувьд олон нийтийн анхаарал, хяналтад байгаагийн хувьд гомдол гаргахаас илүүтэйгээр Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т хүнийг эрхэлсэн ажил, албан тушаал, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно гэснийг, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхдээ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх, нийгмийн дэг журам, ёс суртахуунд харшлахгүй байх ёстой гэснийг тус тус сануулж, сурталчлах нь зүйтэй юм.



3.4 Бусад тохиолдлын дүн шинжилгээ

2021.05.29-ний өдрийн 18:49 цагт “Алтансүвд Нанжаа Алтансүвд” гэх фейсбүүкийн хаягаас “За арай цэцэрлэгийн багш тэргүүн хатагтайтай болж онигоо болохгүй биздээ манайхаан бидэнд Энхбат гуайн стильтэй тэргүүн хатагтай гоё” гэж бичиж, тус

нийтлэлийг бусад хэрэглэгч цааш нь дамжуулжээ. Энэхүү нийтлэлд нэр дэвшигч Д.Энхбатын эхнэр болон нэр дэвшигч У.Хүрэлсүхийн эхнэрийн хоёр зургийг харьцуулж хавсаргажээ.



Энэхүү нийтлэл нь Монгол улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т хүнийг эрхэлсэн ажил, албан тушаал, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно гэснийг зөрчсөн байна.

Иргэний хуулийн 21.6-д “Иргэний нийгэмд эзлэх байр суурьтай холбогдуулан түүнийг сурталчлах зорилгоор болон сургалт, эрдэм шинжилгээний ажил, ажил хэргийн хүрээнд олон нийтийг хамарсан үйл ажиллагааны явцад уг этгээдийг дүрсэлсэн, эсхүл тухайн этгээд өөрийгөө дүрслүүлсний төлөө хөлс, шан харамж авсан бол түүний зөвшөөрөл шаардагдахгүй” гэж заасан бөгөөд дээрх нийтлэлд холбогдох зургийг хавсаргахдаа нэр дэвшигч Д.Энхбатын эхнэр болон

нэр дэвшигч У.Хүрэлсүхийн эхнэрийн зөвшөөрлийг авах шаардлагатай байжээ. Мөн хуулийн 21.5-д зааснаар иргэний дүрсийг гэрэл зураг болон бусад хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлсэн, олон нийтэд үзүүлснээс гэм хор учирсан гэж үзвэл тухайн этгээд гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй. Гэхдээ дээрх нийтлэлд дүрс нь орсон хүмүүсийн хувьд олон нийтийн анхаарал, хяналтад байгаагийн хувьд гомдол гаргахаас илүүтэйгээр Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т хүнийг эрхэлсэн ажил, албан тушаал, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно гэснийг сануулж, сурталчлах нь зүйтэй юм.



ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны үеийн фейсбүүк дэх хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөний зөрчлийн мониторингийн дүгнэлт

- » Энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны мэдээлэл харилцааны голлох сувгуудын нэг нь нийгмийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болох фейсбүүк талбар боллоо. Сонгуулийн сурталчилгааны 15 хоногт нэр дэвшигчидтэй холбоотой 579 мэдээлэл/пост бүртгэж авснаас сурталчилгааны эхний долоо хоногт өдөр дунджаар 34, сүүлийн долоо хоногт 48 мэдээлэл/постыг бүртгэжээ. Эдгээр мэдээлэл/постуудын талаас илүү буюу 56 хувь нь эерэг, 15,5 хувь нь төвийг сахисан хандлагатай байсан бол 28,5 хувь нь сөрөг агуулгатай байв.
- » Сонгуулийн сурталчилгааны хугацаанд нэр дэвшигчидтэй холбоотой нийт мэдээлэл/постод сонгогчдын зүгээс 705,750 удаагийн хариу үйлдэл үзүүлжээ. Өөрөөр хэлбэл, нэг постод дунджаар 1218 хариу үйлдэл үзүүлсэн байна. Фейсбүүк хэрэглэгчид хариу үйлдэл үзүүлэхдээ дэмжих, эсэргүүцэх, шоолох, гайхширах, уурлах, бусдад хуваалцах, санал сэтгэгдэл бичих зэргээр олон янзын сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн. Эдгээр үйлдлийн тал хувьд нь бусадтай хуваалцах буюу шейр хийх үйлдлийг ашигласан бол удаа нь эмож дарах, сэтгэгдэл бичих хэлбэрүүдийг ашиглажээ.
- » Сонгуульд нэр дэвшигч тус бүрээр харьцуулан харвал, АН-аас нэр дэвшигч С.Эрдэнэтэй холбоотой мэдээлэл 43,9%, Зөв хүн электорат эвслээс нэр дэвшигч Д.Энхбаттай холбоотой мэдээлэл 42,3%, МАН-аас нэр дэвшигч У.Хүрэлсүхтэй холбоотой мэдээлэл 27,5%-ийг эзлэв. Харин сонгогчдын зүгээс хариу үйлдэл үзүүлэхдээ нэр дэвшигч У.Хүрэлсүхийн талаар хамгийн их хэлэлцүүлэг өрнүүлсэн бол нэр дэвшигч С.Эрдэнэ олон нийтийн анхаарал татаж “ярианы сэдэв” болж чадсангүй. Өөрөөр хэлбэл, хариу үйлдэлтэй постуудын 75 хувь нь У.Хүрэлсүхийн тухай байсан бол 20% нь Д.Энхбат, 5% нь С.Эрдэнийн талаар байв.
- » Сурталчилгааны эхэн үед фейсбүүк талбарт нэр дэвшигчдийн талаар төвийг сахисан мэдээлэл зонхилж байснаа төгсгөл үед хэт эерэг эсвэл хэт сөрөг “туйлширсан” мэдээллүүд огцом нэмэгдэв. Тодруулбал, сурталчилгааны сүүлийн долоо хоногт эерэг мэдээллийн давтамж 32%, сөрөг мэдээллийн давтамж 16% тус тус өссөн. Эндээс харахад, сурталчилгааны хугацаанд фейсбүүкийг иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл солилцох талбар гэхээс илүүтэй нэр дэвшигчээ магтан дуулах, эсвэл өрсөлдөгчөө буруутган “намнах” зорилгоор түлхүү ашиглаж байна.
- » Сонгуулийн сурталчилгааны хугацаанд фейсбүүк талбарт АН-аас нэр дэвшигч С.Эрдэнийн тухай хамгийн олон эерэг (72.2%) мэдээлэл цацагдсан бол МАН-аас нэр дэвшигч У.Хүрэлсүх (45.3%), Зөв хүн электорат эвслээс нэр дэвшигч Д.Энхбат (36.6%) -ийн тухай тус тус сөрөг мэдээлэл зонхилжээ. Ерөнхийд нь ажиглахад, энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийн фейсбүүк дэх мэдээлэл сурталчилгаа нэр дэвшигч У.Хүрэлсүх, нэр дэвшигч Д.Энхбат нарын дунд өрнөсөн бөгөөд тэдний хэн нь хэн болох, хэн нь сайн эсвэл муу хүн болох талаар яриа хэлэлцүүлэг илүү өрнөсөн байна.
- » Сонгуулийн сурталчилгааны хугацаанд фейсбүүк хэрэглэгчид эерэг мэдээллээс илүү сөрөг мэдээллийг шейр хийж бусдад дамжуулах нь бусад хариу үйлдлээсээ хоёр дахин их байгааг мониторингоор тогтоолоо. Харин сөрөг мэдээллээс илүү эерэг мэдээллийг лайк дарж дэмжих нь гурав дахин их байв.
- » Сонгогчид фейсбүүк талбарт үзэл бодлоо илэрхийлэхдээ туйлшрах буюу хэт нэг талыг дэмжих, эсвэл үгүйсгэх хандлага сурталчилгааны төгсгөл үед эрчимтэй нэмэгдэв. Түүнчлэн хүний эрхийн зөрчил агуулсан сөрөг мэдээлэлд хариу үйлдэл үзүүлэхдээ бусадтай хуваалцаж, дамжуулж улам бүр түгээх, дэвэргэх хандлага нийтлэг ажиглагдав. Тодруулбал, сөрөг мэдээлэлд нийт хариу үйлдэл үзүүлсэн тохиолдлуудын тал хувь нь хуваалцах байдлаар илэрчээ. Сэтгэгдэл бичих нь эмож дарах, шейр хийхээс харьцангуй бага байна.
- » Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны хугацаанд сонгогчдоос хамгийн их хариу үйлдэл авсан сошиал хуудаснуудад 1) мэдээллийн сайтуудын пэйж хуудаснууд, 2) сэтгүүлч гэсэн тодотголтой, эсвэл сэтгүүл зүйгээр танигдсан хүмүүс, 3) улс төрийн намын пэйж хуудас, 4) улс төрчид болон олны танил хүмүүсийн пост/мэдээлэл хамгийн олон хүнд хүрч байв. Гэвч олны танил сэтгүүлчид, улс төрчид, нөлөө бүхий этгээдүүдийн пост/мэдээллийн дор сэтгэгдэл хэсэгт үзэн ядалтын үг хэллэг агуулсан, уриалсан дуудсан өнгө аястай сэтгэгдлүүд олноор цугларч



байна. Өөрөөр хэлбэл, фейсбүүкийн сэтгэгдэл хэсэгт нийтлэгдсэн хүний эрхийн зөрчилтэй 119 сэтгэгдлийн 76 (64%) нь нэр дэвшигчдийг гутаан доромжилсон нэр, хоч өгсөн явдал байв. Жишээ нь: хулгайч өвгөн, мэлхий Эрдэнэ, луйварчин, арчаагүй тоть, гурилсүг янхан гэх мэт үг хэллэг агуулжээ.

- » Энэ удаагийн мониторингийн зорилго нь Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны үеийн фейсбүүк талбар дахь хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөний зөрчлүүдийг бүртгэж авч, хууль зүйн талаас мэргэжлийн тайлбар хийснээрээ онцлог болов. Мониторингийн багийн үзсэнээр хүний эрхийн зөрчилтэй гэсэн 11 жишээнээс хууль судлаач тавыг нь сонгож, Монгол улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг хэрхэн зөрчиж буйд тайлбар хийлээ. Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор хүнлэг энэрэнгүй байх, шударга, алагчлалгүй байх, хүний жам ёсны эрхэд хүндэтгэлтэй хандах, Жендерийн эрх тэгш байдлыг хангах, ялгаварлалгүй хандах зэргээр хүний суурь эрхүүдийг хамгаалдаг. Гэвч нэр дэвшигчдийг үндэслэл нотолгоо, баримтгүйгээр буруутган нэр хоч өгсөн, шоолж доромжилсон, ялгаварлан гадуурхсан, өдөөн

түрхирсан, үзэн ядах үг хэллэг ашигласан 207 пост, 119 сэтгэгдлийг бүртгэгджээ.

- » Иргэн бүр нэр дэвшигчийн тухай, түүний мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны талаар үзэл бодлоо цахим орчинд чөлөөтэй илэрхийлэх эрхтэй хэдий ч Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлийн 3-т заасны дагуу тийнхүү илэрхийлэхдээ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх; үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахуунд харшлахгүй байх ёстой. Иргэний хуулийн 21.3-т заасан бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс бусдын нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан шинжтэй зөрчлүүд илэрснийг тайланд тэмдэглэв.
- » Троллинг буюу “цахим цэрэг”-ийг сонгуулийн сурталчилгаанд ашиглаж буй байдал нь ижил агуулга, ижил текст бүхий сэтгэгдлүүдийг олон давтамжтайгаар зорилготойгоор нийтлэх явдлаар илэрдэг. Энэ удаад нэр дэвшигчдийг гутаан доромжлох, ялгаварлан гадуурхсан нэр хоч өгсөн мессеж, мэдээллийг давтан явуулах, сөрөг мэдээллийг ятгуулан үнэмшүүлэх зорилготойгоор давтамжтай нийтлэх зэрэг зөрчлүүд бүртгэгдэв.

ТАВ. ЦАХИМ ОРЧИНД ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖ

Нэг. Цахим орчинд тэр дундаа фейсбүүк талбарт хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлд дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- “Монгол Улсын Ерөнхийлөгчийн Сонгуулийн Тухай Хууль”-ийн 42 дугаар зүйлд сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах асуудлыг зохицуулахдаа нэр дэвшигчийн болон нам, эвслийн өөрийн тус бүр нэг цахим хуудас, бусад цахим хуудас ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахдаа сэтгэгдэл бичихгүй тохиргоотой байхыг заажээ. Ингэснээр сонгогчид үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг хязгаарласан тул үг заалтыг эргэн харах, өөрчлөх;
- Харилцаа Холбооны Зохицуулах Хороонд бүртгүүлээгүй цахим хуудас дахь мэдээллийг дамжуулах асуудлыг зохицуулаагүй орхисноороо нэр дэвшигчид тэнцвэргүй, хууль тогтоомжид нийцээгүй мэдээллийг сонгогчдод хүргэх, шударга бус, хүний эрх, эрх чөлөөний зөрчил нийтлэг гарахад нөлөөлж байгааг анхааран судлах;
- Цахим орчинд сонгуультай холбоотойгоор үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг Зөрчлийн тухай хуулийн 17 дугаар бүлэг, Эрүүгийн хуулийн 14.8

дугаар зүйл, Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлээр тус тус зохицуулж, мөн эдгээр хуулиар нэр дэвшигчдийн нэр төр, алдар хүндийг хамгаалсан байх бөгөөд нэр дэвшигчдийн талаар худал болон илт худал мэдээллийг тараасан үйлдэлд хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан. Эдгээр зохицуулалтад “худал мэдээлэл” ба “илт худал мэдээлэл” гэдгийг тодорхойлоогүй, түүнчлэн нэр дэвшигч холбогдох бодит, зөв мэдээллээ урьдчилж нийтэд мэдээлснээс хойш худал мэдээлэл тараасан эсэхийг харгалзах талаар орхигдуулсныг засаж залруулах; улмаар эрх бүхий хууль, хяналтын байгууллагуудаар Ерөнхийлөгчийн сонгуулийн хугацаанд эдгээр хуулийн дагуу хэчнээн гомдол ирж, хэрхэн шийдвэрлэсэн талаар дахин мониторинг хийж баримтжуулах;

- Нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон “худал мэдээлэл” тараасан бол Зөрчлийн тухай хуулиар 5 сая төгрөгөөр, “илт худал мэдээлэл” тараасан бол Эрүүгийн хуулиар



- 450,000 төгрөгөөр торгохоор байгаа нь зөрчил, гэмт хэргийн ялгааг харгалзаагүй, зөрчлийн шинж байдал ба шийтгэлийн төрөл, хэмжээг уялдуулаагүй нь зөрчлийн шинжтэй үйлдлийг эрүүгийн хэргийн журмаар шалгаж шийдэх эрсдэл, үр дагаврыг үүсгэж буйг засах;
- “Цахим цэрэг”-ээр дамжуулан цахим орчинд хэрэглэгчид, сонгогчдын тархи угаах үйл ажиллагаа улс орнуудад нэмэгдэж байна. Мониторингоор фейсбүүк талбарт нэр дэвшигч, түүний гэр бүлийн нэр хүнд, нэр төр, алдар хүндэд үндэслэлгүйгээр халдах, хүний эрхийн зөрчил нийтлэг буйг харгалзан тролл, бот хаягуудад хяналт тавих техникийн шийдлийг фейсбүүк компанитай хамтран боловсруулж хэрэгжүүлэх;
 - Сонгогчдын цахим орчинд мэдээлэлтэй зөв харьцах, мэдээлэлд шүүлтүүртэй мэдлэгтэй хандах (media literacy, digital literacy) чиглэлд

сургалт, соён гэгээрлийн ажлууд зохион байгуулах, хүний эрх, эрх чөлөөнд мэдрэмжтэй хандах, үзэн ядалтын үг хэллэгээс зайлсхийх, түүнийг цааш түгээх эсэхээ (share) шүүн тунгаах, сонгуулийн үеийн хууль эрх зүйн орчныг таниулан сурталчлах чиглэлд төр, иргэний нийгмийн байгууллагууд үе шаттай ажлуудыг зохион байгуулах;

- Нийгмийн хэвлэл мэдээлэлд гол нөлөөлөгчид болох улс төрд нөлөө бүхий этгээд, соёл урлагийн одод, сэтгүүл зүйн салбарын төлөөлөл, олны танил хүмүүс цахим орчны зөв хэрэглээгээр үлгэрлэн манлайлах, өөрсдийн постын сэтгэгдэл хэсэгт хяналт тавих, шаардлагатай тохиолдолд модератор хийх, сэтгүүлчид цахим орчинд ч ёс зүйн зарчмаа чанд мөрдөн ажиллах зэргээр өөрийн зохицуулалтыг тууштай дэмжин хөгжүүлэх;

Хоёр. Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 7-д заасан нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд тараах, Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйлд сонгуульд оролцогч нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараах зөрчлөөс сэргийлэхийн тулд дараах арга хэмжээ авахыг зөвлөж байна. Үүнд:

- Нэр дэвшигч, түүний багийн зүгээс дээрх цахим орчинд гарсан нийтлэлд дурдсан сөрөг буюу худал агуулгыг албан ёсоор бодит эх сурвалж, бүрэн мэдээллийг олон нийтэд танилцуулж няцааж байх;
- Нэр дэвшигч, түүний хамаарал бүхий этгээдүүд олон нийтийн буюу сонгогчдын хяналтад сайн дураараа орсон тул цагдаагийн байгууллагад гомдол гаргахаас илүүтэйгээр бодит, бүрэн мэдээллийг олон нийтэд тухай бүр өгч буруу ойлголт үүсэхээс сэргийлэх;
- Нийтлэл, мэдээлэл нийтлэгчдийн хувьд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Иргэний хуульд заасан хариуцлага хүлээхээс зайлсхийхийн тулд мэдээллийн эх сурвалжаа тухай бүр тодорхой оруулах, ялгаварлан гадуурхсан агуулгаас зайлсхийх;
- Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т хүнийг эрхэлсэн ажил, албан тушаал, боловсрол зэрэг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхаж үл болно гэснийг сонгогчид, нэр дэвшигчдийн дэмжигчдэд сануулж, сурталчлах агуулга тухайн сонгуулийн сурталчилгааны нэг үндсэн хэсэг байхаар зохицуулах;
- Түүнчлэн, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Иргэний хуульд заасан хариуцлага хүлээлгэх талаар гомдол гаргасан тохиолдолд түүнийг шалгаж, шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудын зүгээс тухайн нийтлэл, мэдээлэлд дурдсан агуулгатай холбоотой урьдчилж бэлтгэсэн бодит, бүрэн мэдээлэл байсан эсэх, тийнхүү мэдээлэл байхад зориуд тухайн нийтлэл, мэдээллийг нийтэлсэн эсэхийг заавал харгалздаг байх;



ЗУРГАА. ХАВСРАЛТ

Хавсралт 1. МОНИТОРИНГИЙН ХҮРЭЭНД БҮРТГЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙГ НИЙТЭЛСЭН ФЕЙСБҮҮК ХУУДАСНЫ НЭРС

№	Фейсбүүк хуудсын (пейж) нэрс	Дагагчдын тоо
1	Alim.mn	88,968
2	amjilt	365,510
3	Assa Mn	146,542
4	ASU.MN	125,375
5	Baasankhuu Oktyabri	15,569
6	Badmaanyambuu Bat-Erdene	154,167
7	Bataar.mn	66,707
8	Batbold Boldoo	65,300
9	Bilguun Adiyasuren	52,333
10	Buyan Choi	12,528
11	Check.mn	30,699
12	Clubhouse.mn	1,400
13	Democratic Party Ардчилсан нам	11,127
14	Dens.mn	25,044
15	DMNN	319,285
16	Eagle News	408,524
17	Ekh survalj	2,967
18	Enter.mn	16,794
19	Erdene Sodnomzundui	157,257
20	erennews.mn	32,282
21	ETCITY.mn	21,271
22	ETV HD	387,042
23	Focus.mn	21,798
24	Franchise Anr	42,900
25	Ganbat Munkhbold	11,900
26	Gereg.Mn	59,710
27	Goviainews.mn	10,904
28	Gundegmaa Baldan	48,400
29	HERO entertainment	17,815
30	iSee.mn-Үнэнийг мэдээлнэ	39,133
31	iToim.mn	155,718
32	Jadambaa Otgonbayar	55,512
33	Jargal Defacto	86,366
34	Khayankhyarvaa Tugs	1,543

35	L News.mn	19,289
36	livetv.mn	312,961
37	Mass	588,181
38	MGLRADIO - Дэлхийн Монголчуудын Радио	622,638
39	Molpedia TV	332,644
40	Mongol Mgl Бид	59,104
41	NB HD Television	60,203
42	News.mn	257,027
43	Newspress.mn	163,952
44	NTV Мэдээ	183,468
45	Odbayar Demos.mn	23,635
46	Odgerel Damchaa	104,800
47	ODOD.mn	105,360
48	Oyundary Tsagaan	16,930
49	Paparazzi.mn	411,404
50	Sarnai Tuya	184,000
51	SBN tv	267,448
52	Shirchin Baatar	22,746
53	Shuud.mn - Өнөөдрөөс сайхан маргааш	157,257
54	shuur	23,010
55	Sonin.mn	231,345
56	Sport Window Olhoo	12,248
57	Temka Temkaa	132,100
58	TIME MN	119,132
59	Topshop Mongolia	17,321
60	Tovch.mn	374,708
61	Trend news	17,028
62	Tsend Ariukaa	76,300
63	TV4 mongolia	295,298
64	TV6	18,535
65	TV6 Mongolia	226,457
66	TV8 Mongolia	406,157
67	UB LIFE	100,782
68	Ulsturch.mn - Улстөрч.мн	118,193



69	Undesten.mn	93,953
70	Updown.mn	36,028
71	Uyanga Gantumur	122,422
72	Uyanga Tsoggerel	43,309
73	zarig.mn	731,340
74	Zindaa.mn	220,329
75	zogii	134,241
76	Zorigt Enkhee	73,500
77	Zugii.mn	137,938
78	Zuuniimedee	26,150
79	Аз Жаргал	131,400
80	АН-ын жирийн гишүүдийн эсэргүүцлийн хөдөлгөөн	4,122
81	Ардчилал Мандтугай	1,694
82	Ардчилал сайт Ardcihal.mn	117,482
83	Ардчилсан нам	4,502
84	АРДЫН ҮНЭН	3,589
85	Ардын Хүү	4,990
86	АРСЛАН.mn Arslan mn	102,262
87	Архангай аймаг	20,191
88	Архангай аймгийн Ардчилсан нам	4,350
89	Архангай аймгийн Монгол Ардын Нам	6,873
90	Б.Жаргалсайхан Бүгд Найрамдах Нам	37,579
91	Багануур дүүргийн Ардчилсан намын албан ёсны хуудас	5,453
92	Бадралын МӨНХДӨЛ	9,596
93	Бадрахын НАЙДАЛАА	26,846
94	Баяд Монгол Бүсгүй	73,500
95	Баянгол дүүргийн Ардчилсан Нам	8,384
96	Баян-Өлгий шуурхай мэдээ	17,356
97	Би Mongol	169,369
98	Бөөгийн Шүлэглэлийн Өнгө Аяс	27,800
99	Бямбацогт Сандаг	116,139
100	Галбадрахын Найманжин	17,832
101	Ганболд Пүрэв	6,853
102	Гоо Гоо	10,732
103	Дамбын Батлут	28,473
104	Дангаасүрэнгийн ЭНХБАТ	85,000

105	Дархан Ардчилсан Залуучуудын Холбоо	1,860
106	Доноровын Гантулга - Gantulga Donogov	53,218
107	Дээдсийн амьдрал сонин	36,766
108	Жаргал Дарханбаяр	8,628
109	Жаргалсайхан Золжаргал	23,789
110	Завхан Хөдөлмөрийн Үндэсний Нам	1,767
111	Залуусын орон зай	105,799
112	ЗАР МЭДЭЭЛЭЛ	183,700
113	Зөв ХҮН Электрат эвсэл	9,834
114	Зөв.мн	168,236
115	ИРГЭДИЙН ДУУ ХООЛОЙ	237,600
116	Иргэдийн цаг livetv.mn	3,471
117	Их Заргач	14,000
118	Лхагвасүрэн Мягмарсүрэн	4,972
119	Монгол Ардын нам	99,100
120	Монгол Ардын Намын Шинэчлэл, хөгжлийн хороо	10,410
121	Монгол хүү	1,600
122	Монголчуудыг Чадна	71,000
123	Монголын ардчилсан иргэдийн нэгдэл	1,214
124	Монголын татаадаг бичлэгүүд	121,900
125	Нийгмийн Ардчилал Монголын Залуучуудын Холбоо	66,301
126	Од Ко	15,913
127	Одонгийн Цогтгэрэл Tsogtgerel Odon	62,479
128	Олуулаа	144,400
129	Оном сан	82,927
130	Онцгой Хүргэлт Дэлбээ	10,783
131	Оросоогийн Түвшиндэмбэрэл	4,567
132	Орхон аймгийн Монгол Ардын Нам	4,551
133	Отгонбаяр Отгон	6,975
134	Өрөг.mn	172,563
135	Парламент TV / Parliament TV /	218,096
136	Пүрэвсүрэнгийн Наранбаяр-Naranbayar Purevsuren	46,659
137	Рэгзэнгийн Шинэгэрэл	90,700



138	Сайнбуянгийн Амарсайхан	173,073
139	Сайхан Монгол	4,000
140	Самданнамын МӨНХЧУЛУУН	40,220
141	Сонгууль - 2021 / Election - 2021 deedsiinamidral.mn	1,032
142	Сонин мэдээ	9,264
143	Сошиализм & Socializm	3,400
144	Сэтгүүлч Б.Отгон	10,256
145	Сэтгүүлч Н.Урантогтох	218,770
146	Сэтгүүлч Хүрэл	4,907
147	Сэтгэл Зүйч Я. Батхүү	4,963
148	Тамир телевиз /Архангай аймаг/	4,997
149	ТВ24	14,539
150	Төмөрдөшийн Баярхүү	36,924
151	ТУГ.мн	116,630
152	Түшиг Хишигтогтох	12,050
153	У.Хүрэлсүхийг дэмжигчид	42,600
154	Улаан бал	182,292
155	Улаанбаатарын Унаган Хүү	76,300
156	Уухай хөдөлгөөний дэмжигчид	36,000
157	Х.Ган-Ялалт Мөрч.мн	7,524
158	Хан-Уул дүүрэг /www.arslan.mn/	9,564
159	Хар дэвтэр	2,767
160	Харьцуулалт	103,473
161	Хатуу мэдээ	56,500
162	Хорин Дөрвөн Цаг	105,679
163	Хотын залуус	68,645

164	Хөвсгөл Ард Түмний Телевиз	16,251
165	Хөдөлмөрийн Үндэсний Нам - ХҮН	30,224
166	Хурандаа У.Хүрэлсүхийг дэмжигчид	205,100
167	Хүүгийг дэмжигчид	4,500
168	Хүчирхэг Монгол	98,658
169	Хэнтий аймгийн Монгол Ардын Нам	6,000
170	Хэрсүү Монгол	1,100
171	Цахим толь	110,745
172	Цензургүй ЯРИА	71,524
173	Цензургүй Яриа-Цензургүй Сурвалжлага	70,100
174	Цэц.мн	8,303
175	Чамайг татаагаад өгөө л дөө	221,181
176	Чимэдийн Хүрэлбаатар Khurelbaatar Chimed	135,000
177	Чинбатын Батзүл	6,937
178	Чулуунбаатарын Чулуунцэцэг	8,938
179	Шатрын Багш	144,400
180	Шинэ Завхан ТВ	15,124
181	Шуурхай мэдээ	129,719
182	Шуурхай.мн	49,900
183	Шүгэл үлээгчид	23,900
184	Элгээ Хайрлая	71,610
185	Эмүжин	138,225
186	Энхтайваны Бат-Амгалан	32,262
187	Эх сурвалж	5,417

Нэмэлт тайлбар:

- Энэхүү хүснэгтэд зөвхөн *public* буюу нээлттэй мэдээлэл тохиргоотой фейсбүүк хуудаснуудыг (*пейж*) хамруулав. Мониторингийн хүрээнд фейсбүүк хуудаснуудаас гадна *public* буюу нээлттэй мэдээлэл тохиргоотой хувь хүний аккаунтуудын мэдээллийг хамруулсан ч хувь хүний аккаунтын мэдээллийг нууцлах үүднээс тус хүснэгтэд оруулаагүй болно.

- Фейсбүүк *пейжийн* дагагчдын тоог судалгааны дата мэдээлэлд сэдвийн хүрээнд хамаарагдах мэдээлэл/пост бүртгэгдсэн өдрөөр нь бүртгэж авсан болно. Өөрөөр хэлбэл Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны үед тухайн хуудсыг дагасан дагагчдын тоогоор нь тус бүр бүртгэсэн болно.



Хавсралт 2.

ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ

2 дугаар зүйл

Хүн бүр энэ Тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой. Мөн түүнчлэн

тухайн хүнийг харьяалдаг улс буюу нутаг дэвсгэрийн улс төр, эрх зүй болон олон улсын статус ямар ч байлаа гэсэн, тухайлбал, тусгаар тогтносон буюу асрамжид байгаа, өөрөө эс удирдах зэрэг бүрэн эрхт байдал нь ямар ч байдлаар хязгаарлагдмал байсан тэр нь ялгаварлах үндэс болох ёсгүй.

ИРГЭНИЙ БОЛОН УЛС ТӨРИЙН ЭРХИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ПАКТ

17 дугаар зүйл

1. Хэнийг ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь

нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно.

19 дүгээр зүйл

1. Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй.
2. Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.
3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх

нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараах шаардлагаас үүдэн гарсан байх ёстой :

- a/ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх;
- b/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах.

20 дүгээр зүйл

Тайван хуран цуглах эрхийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд үндэсний буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах, эсхүл

бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс хуулийн дагуу тогтоосноос өөр хязгаарлалт хийж болохгүй.

1 дүгээр зүйл

1. Гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

14.2 Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.

16.11 Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш

16.16 Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;

17.2 Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх

Энэхүү мониторингийг Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний хүрээнд Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр Эрэн Сурвалжлах Сурвалжлагчдын Төлөө Төвийн судлаач, багш нарын баг хараат бус хуульч судлаачидтай хамтран гүйцэтгэлээ.

Мониторингийн тайланд дурдагдсан тоо баримт, дүгнэлт, зөвлөмж нь судалгааны багийн байр суурь, дүгнэлт болно.